

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

МОНГОЛ УЛСЫН АНХДУГААР АУДИТЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

ГҮЙЦЭТГЭСЭН КРЕЙН ВАЙТ ЭНД АССОУШИЭТС

МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД
БАЙДЛЫН САНААЧИЛГАД ЗОРИУЛАН ДЕСМОНД КРЕЙН,
КРИСТОФЕР ВАЙТ, НЕЙЛ СИНКЛЕЙР БОЛОН ФИЛИПП
ЖЕФФЕРСОН НАР БЭЛТГЭВ.

Орчуулгыг гүйцэтгэсэн Д. Ганхуяг
(Пакт Монгол ТББ)

2007 он

Агуулга

Гүйцэтгэх хураангуй	4
Бүлэг 1: Үндэслэл	5
Бүлэг 2: Хандлага	7
Бүлэг 3: Үйл явц	10
Мэдээлэл цуглуулах	10
Нэгтгэл	11
Анхан шатны харьцуулалт	11
Зөрүүг тодруулан шинжилсэн нь	13
Бүлэг 4: Тодруулга	16
Нэгтгэсэн зөрүү	16
Татвар, төлбөрүүд	16
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	16
Буцаан авсанаа хассан НӨАТ	16
Гаалийн татвар	17
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	18
Үл хөдлөх хөрөнгийн татвар	18
Онцгой татвар (шатах, тослох материал импортлосон бол)	19
Авто бензин, дизелийн түлшний албан татвар	19
Автомашин, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	19
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	19
Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	20
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн ордын нөхөн төлбөр	20
Газрын төлбөр	20
Ус ашигласны төлбөр	20
Ойгоос мод, түлээ бэлтгэсний төлбөр	21
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	21
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	21
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	21
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	22
Гаалийн үйлчилгээний хураамж	22
Төрийн өмчийн ногдол ашиг	22
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	23
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр	23
Мөнгөн тусламж, хандив	23
Маягтуудыг бэлтгэх	24
Маягтуудын загвар	25
Маягтуудыг бөглөх зааварчилгаа	25
Бүлэг 5: Асуудлууд	26
Цаг хугацаа болон цаг баримтлах байдал	26
Засгийн газрын бүрэн бус мэдээлэл	26
Маягтуудын загвар	27
Маягтуудыг бэлтгэхэд анхаарах зүйлс	27
Маягтуудыг бөглөх зааварчилгаа	27
Маягтад багтах төлбөрүүдийн талаарх нэгдсэн үзэл баримтлал	28

НӨАТ	28
Гаалийн татвар	28
Цаг хугацааны зөрүү- хасалт	28
Төрийн байгууллагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг	29
Бүлэг 6: Санал, зөвлөмжүүд	30
Шийдэгдээгүй зөрүүнүүд	30
Цаг хугацаа болон цаг баримтлах байдал	30
Засгийн газрын бүрэн бус мэдээлэл	31
Маягтуудын загвар	32
Маягтуудыг үнэн зөв бэлтгэх нь	32
Маягтуудыг бөглөх зааварчилгаа	32
НӨАТ	32
Гаалийн татвар	32
Цаг хугацааны зөрүү-хасалт	33
Төрийн болон орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг	33
Бүлэг 7: Дүгнэлт	34
Товчлолууд	35
Хавсралтууд	35
Компанийн тайлангууд	
Алтан Дорнод Монгол	
Адуунчулуун	
Багануур	
Бороо Голд	
Чинхуа МАК Нарийн Сухайт	
Коулд Голд	
Дацан Трейд	
Эрдэс Холдинг	
Эрдэнэт УБК	
Гацуурт	
Айвенхоу Майнз Монголиа Инк	
Жамп	
Монголын Алт	
Эм Жи Эйч	
Монгол Газар	
Монголросцветмет	
Петро Чайна Дайчинь Тамсаг	
Шарын Гол	
Шим Технологи	
Шинь Шинь	
Шивээ Овоо	
Шижир Алт	
Тавантолгой	
Цайрт Минерал	
Улз Гол	

ГҮЙЦЭТГЭХ ХУРААНГУЙ

Монгол улсын анхны ОУИТБС-ын оролцогч талуудын тайлагнасан маягтуудыг харьцуулан нэгтгэх үйл ажиллагааны хүрээнд уул уурхайн компаниудаас төлөгдсөн нийт төлбөр нь Засгийн газрын зүгээс хүлээн авсан дүнгээс зөрүүтэй байгаа тэрхүү дүнгүүдийг нэгтгэн гаргаж, энэхүү эцсийн тайланг гаргасан болно.

Засгийн газрын хүлээн авсан төлбөрийн талаарх мэдээллийн байдлаас үзэхэд эдгээр нь бүрэн бус, буруу алдаатай бөглөгдсөн болох нь ил байлаа. Энэхүү баримтыг бид өөрсдийн үйл ажиллагааны явцад, ялангуяа их хэмжээний зөрүү ажиглагдаж байгаа хэсгүүдийг дагалдах судалгаа, тодруулгын хүрээнд судлан үзэх үеэр бид ажигласан юм. Тодорхойлон хэлвэл олон тооны яам, агентлагууд, аймаг, сумд нь уул уурхайн компаниудаас хүлээн авсан төлбөрийнхөө талаар бүрэн хэмжээгээр мэдээлэхгүй байх, үлдэх хэсэг нь бүрэн бус, буруу мэдээллийг төвдөө тайлагнаж байгаа нь ажиглагдлаа.

Энэхүү нэгтгэлийн хүрээнд ажиглагдсан өөр нэгэн санаа зовоож буй асуудал нь тайланд дурдсан мэдээлэлд гарч буй их хэмжээний зөрүү, төлсөн болон хүлээн авсан мөнгөн дүнгүүд хоорондоо үл нийцэх байдал байлаа. Компаниудын зүгээс зарим төрлийн татварыг тооцоолохдоо олон тооны татвар, төлбөрийг нэгтгэн, багтаан боддог нь харагдсан ба энэ нь Засгийн газрын зүгээс тайлагнаж буй дүнгээс ихээхэн зөрүүтэй байлаа. Энэ нь тухайн хэсгүүдийг хэрхэн бөглөх, тайлагнах талаарх тодорхой нарийвчилсан зааварчилгаа дутуу байгаагаас ихээхэн хамааралтай болохыг харуулж байна.

2006 оны нэгтгэл дээр гарсан олон тооны шийдэгдээгүй үлдсэн мэдээлэл бүрийн учир шалтгааныг нарийвчлан тодруулах нь зохимжтой практик сонголт биш байлаа. 2007 оны жилийн эцсийн асар их ажлын ачаалалтай энэхүү цаг үед компаниудын зүгээс ч, Засгийн газрын зүгээс ч энэ их хэмжээний, өргөн хүрээний ажлыг, ялангуяа одоогийн энэхүү цаг мөчид хуучирсан буюу 12-24 сарын өмнөх мэдээлэл дээр ажиллан, нэгтгэн бүрэн шийдэж, гүйцэтгэх нь маш хэцүү бөгөөд харин энэ асуудлыг Монголын ОУИТБС цааш цаашдын нэгтгэсэн тайлан гаргах үйл ажиллагаандаа анхаарах шаардлагатай байна.

Дээр дурдагдсан асуудлууд нь цаашид анхаарах гол, үндсэн асуудлуудыг тусгасан болно. Цаашдын нэгтгэсэн тайлан гаргах үйл ажиллагааг амжилттай, үр дүнтэй болгохын тулд дараах зүйлсийг цаашид анхаарах шаардлагатай байна.

А. Засгийн газрын зүгээс өөрийн бүх яам, агентлаг, орон нутгаас төлөгдсөн татвар, хураамж болон уул уурхайн компаниудын үзүүлсэн мөнгөн тусламжийн талаар үнэн зөв мэдээлэл авч байх системийг бий болгох, болон

Б. ОУИТБС-ын зүгээс маягтуудыг хэрхэн бөглөх талаарх зааварчилгаануудыг сайтар хянан үзэж, энэхүү тайлан дээр дурдагдаж байгаа олон төрөл зүйлс, хэсгүүдэд тавигдах шаардлагуудад нийцүүлэн зааварчилгааг тохируулах, боловсруулах

Бүлэг 1: Үндэслэл

Энэхүү тайлан нь Монгол улсын анхдугаар нэгтгэсэн тайлан гаргах үйл ажиллагааны эцсийн үр дүнг нэгтгэн гаргасан болно. Энэ тайлан 2006 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон хуучин мэдээллийг хамаарах бөгөөд энэхүү дурдсан цаг хугацаанаас хойш хууль тогтоомж, татвар болон хэрэгжиж буй үйл явцад ихээхэн өөрчлөлт орсон болох нь дамжиггүй.

Монголын ОУИТБС-ын (Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга) хүсэлтээр бид энэхүү нэгтгэлд хамрагдсан уул уурхайн 25 компанийн тайланг нэг бүрчлэн гаргасан юм. Эдгээр тайлангуудыг хавсаргасан ба компанийн тайлангууд нь энэхүү нэгдсэн тайлангийн нэгээхэн бүрэлдэхүүн хэсэг болно.

Энэхүү тайлан дээр дурдагдсан тоон мэдээлэл нь тухайлан дурдаагүйгээс бусад тохиолдолд ,000 буюу мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн болно.

ОУИТБС нь Засгийн газрууд, иргэний нийгмийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын дэлхий нийтийн эвслийг байгалийн баялгаас (газрын тос, байгалийн хий болон уул уурхайн ашигт малтмал) олж буй орлогын төлөлт ба хүлээн авалтыг илүү ил тод болгох зорилгын дор нэгтгэдэг. Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгаас олж буй орлого нь ийм төрлийн нөөц баялаг ихтэй орнуудын эдийн засгийг өөрчилж, ядуурлыг бууруулахын зэрэгцээ нийт хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж чаддаг юм.

Монгол улсын Засгийн газраас ОУИТБС-д нэгдэн орох болсоноо 2005 онд зарласан билээ. Үүний дараагийн шатны үйл ажиллагаа болгон Засгийн газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөл бүхий ОУИТБС-ын Үндэсний Зөвлөл болон Олон талын оролцоот Ажлын хэсгийг байгуулан ОУИТБС-ыг хэрэгжүүлэх болжээ. ОУИТБС-ыг өдгөө Дэлхийн Банкны ОУИТБС-ын Итгэлийн сангаар дамжуулан олгосон тэтгэлэгийн хүрээнд санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Цомхон бүтэцтэй Ажлын албаар дамжуулан үйл ажиллагаа явуулж буй Ажлын хэсэг нь Монголын ОУИТБС-ын үйл ажиллагааны хөтөлбөр болон талуудын харилцан тохиролцсон тайлагнах маягтуудыг бэлтгэн гаргаж, тухайн маягтуудыг уул уурхайн компаниудын зүгээс төлсөн татвар хураамж, Засгийн газрын зүгээс хүлээн авсан татвар хураамжийг бүх түвшинд (үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн) тайлагнахад ашиглах талаарх зөвшилцөлд бүрэн хүрчээ.

Тухайн санаачлагад нэгдэн орох анхны үе шат болох ОУИТБС-ын Үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан, маягтуудыг бэлтгэн гаргах үе шатнаас одоо бодит хэрэгжилтийн үе шатандаа Монгол улс нэгэнт шилжин ороод байна.

Засгийн газар болон уул уурхайн компаниудын зүгээс ОУИТБС-ын тайлангын маягтуудыг бүрэн хэмжээгээр бөглөн, тайлагнаж дуусгасны үндсэн дээр ОУИТБС-ын зүгээс биднийг Олон улсын аудитороор сонгон авч Монгол улсын хэмжээнд хамгийн анхны нэгтгэсэн аудитын тайлан гаргах үүргийг ноогдуулсан билээ. Анхны Монголын ОУИТБС-ын тайланг ойлгомжтой, удирдахад хялбар болгох зорилгоор компанийн зүгээс төлсөн нийт төлбөрийн хамгийн доод түвшинг 200,000,000 төгрөгөөр тогтоон зөвхөн 2006 оны санхүүгийн жилийг хамруулах болсон юм. Энэхүү анх удаа хийгдэж буй тайлангын үр дүнд Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн 25 томоохон компанийн үйл ажиллагааг дүгнэн харууллаа.

ОУИТБС-ын гаргасан Гүйцэтгэх ажлын цар хүрээ нь энэхүү төслийн зорилго болон төслийн хүрээнд хийх ажлуудыг дараах байдлаар тодорхойлсон болно.

Зорилтууд

Энэхүү зөвлөх төслийн зорилтууд нь Олон улсын ОУИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан үйл явцын дагуу уул уурхайн салбарын хийж буй төлбөр болон үүний хүлээн авалтын талаарх ил тод болон хариуцлагатай байдлыг баталгаажуулах зорилготой. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэх ажил нь уул уурхайн салбарт 2006 онд хийгдсэн төлбөр, тэдгээрийг хүлээн авсан байдлын талаар олон улсын, бие даасан аудиторроор нэгтгэл, дүн шинжилгээ хийлгэх явдал юм.

Гүйцэтгэх ажлууд

Энэ хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагаа нь уламжлалт аудитын үйл ажиллагаа биш юм. Гэхдээ энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэхэд аудитын дадлага, туршлага ихээхэн шаардлагатай. Тиймээс олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн аудиторын ур чадварыг энэхүү үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор татан оролцуулсан болно. Сонгогдсон аудитор нь:

- А. 2006 оны туршид уул уурхайн компаниудын хийсэн бүх төлбөр, тухайн жилд Засгийн газрын хүлээн авсан бүх төлбөрт шинжилгээ хийх. Энэхүү шинжилгээ нь хамгийн анхан шатны түвшинд уул уурхайн компани бүрийн бие даан тайлагнасан маягтууд болон Засгийн газрын зүгээс компани бүрээр гаргасан маягтууд дээр суурилах болно. Шаардлагатай тохиолдолд аудиторуд нь тухайн төлбөр болон тэдгээрийг хүлээн авсан талаарх хамаарах бүх анхан шатны мэдээлэл, баримтыг шалгаж болно.
- Б. Англи болон Монгол хэл дээр нэгдсэн тайланг гарган үүндээ нэгтгэсэн байдлаар компаниудын хийсэн төлбөр болон Засгийн газрын зүгээс хүлээн авсан талаарх мэдээллийг дүгнэн оруулна. Аудитор нь холбогдох бүх талуудтай хамтран ажиллаж төлбөр болон тэдгээрийн зөрүүний талаарх тайлбарыг гаргах бөгөөд мөн тайлан нь ямарваа нэгэн тайлбаргүй, учир нь тогтоогдоогүй зөрүүний талаарх мэдээллийг багтаана. Тайланд аудиторын зүгээс мэдээллийн чанар болон энэхүү үйл явцын талаарх санал бодлыг мөн тусгана. Аудиторууд нь энэхүү үйл явцыг цаашид хэрхэн сайжруулж болох талаарх санал, зөвлөмжүүдээ мөн багтаана.

Гүйцэтгэх ажлын тодорхойлолтод мөн дурдсанчлан аудиторуудын гүйцэтгэх үүрэг нь санхүүгийн бүх баримт бичгүүдэд шалгалт хийх, хянах болон дүгнэлт гаргах явдал биш бөгөөд харин аудиторт өргөн барьсан санхүүгийн тайлангууд дээр өөрсдийн санал бодол, дүгнэлтээ илэрхийлэх явдал юм. Энэхүү санал бодлоо илэрхийлэхдээ аудитор нь Олон улсын аудитын стандартуудыг баримтлах бөгөөд тухайн системийг үнэлэх өөрийн хүрээ болон санхүүгийн тайланд дурдагдсан баримтуудын түвшинд үнэлэлт дүгнэлт хийх болно.

Бүлэг 2: Хандлага

Энэхүү хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ бид Олон улсын аудитын стандартуудыг баримталсан бөгөөд тухайн стандартууд болон гэрээний дагуу зөвшилцсөн бүхий л үйл явцуудыг үйл ажиллагаандаа бүрэн ашиглан, хэрэгжүүлсэн болно. Бидний баримталсан үйл явц, хандлага болон аргачлал нь 2007 оны 10 сарын 17-ны өдрийн Техникийн төсөлд тусгагдсан бөгөөд энэхүү тайланг ойлгоход тус болох мэдээлэл хүргэх үүднээс доор мөн товч дурдагдсан болно.

Төслийн зорилго нь ил тод байдлыг бий болгоход шаардагдах мэдээллээр ханган өгөх явдал юм. Төлбөрийг буруу зарцуулан удирдсан болон авлигын эх үүсвэр болгосон зэрэг үндэслэлийг гарган ирэх нь гол бус харин хариуцлагатай байдлыг бий болгоход туслалцаа үзүүлэхүйц мэдээллээр хангах явдал юм.

Гүйцэтгэх ажлын тодорхойлолтод зааснаар шаардлагатай тохиолдолд аудитор нь төлбөр болон түүнийг хүлээн авсан талаарх мэдээлэл, баримтуудтай танилцах эрхтэй ч энэ нь аудитор нь баримт, ваучер зэрэг бүх анхан шатны мэдээллийг бүрэн шалгана гэсэн утга агуулаагүй болно.

Мөн энэхүү төслийн Гүйцэтгэх ажлын тодорхойлолтод тухайн компани болон Засгийн газрын хэмжээний нууц мэдээлэл, баримтад нэвтрэн орох талаарх хууль эрх зүйн үндсийг бүрэн заагаагүй. Харин бидний зүгээс мэдээлэл хүссэн хүсэлт гарган үүнийг компаниуд сайн дурын үндсэн дээр биелүүлэх нөхцлийг сонгосон болно.

Гүйцэтгэх ажлын тодорхойлолтоор бидэнд 2006 оны туршид компаниудын зүгээс Засгийн газарт хандан хийсэн төлбөр, Засгийн газрын зүгээс компаниудаас хүлээн авсан төлбөрийн талаарх бүх материалууд дээр дүн шинжилгээ хийх шаардлага тавьсан. Мөн үүнд дурдсанаар дүн шинжилгээ нь компани болгоны бөглөн өгсөн тайлагнах маягт, Засгийн газрын зүгээс компани болгоноор гаргасан маягтууд дээр үндэслэн хийхийг даалгасан болно.

Гүйцэтгэх ажлын тодорхойлолт нь биднээс Засгийн газрын тайлагнасан төлбөр хүлээн авсан талаарх мэдээллийг уул уурхайн компаниудын зүгээс тайлагнасан дүнтэй нэгтгэн, харьцуулан нийцүүлэх, мөн Засгийн газрын зүгээс тайлагнаж байгаа мэдээ нь бүрэн, үнэн зөв эсэхийг шалгахыг үүрэгдсэн юм.

Засгийн газрын зүгээс ямар нэгэн татвар, төлбөр, хураамж зэрэг дээр тайлагнасан дүн нь компанийн зүгээс тайлагнасан дүнтэй нийцсэн тохиолдолд Засгийн газрын тайлагнасан дүн нь бүрэн баталгаажна. Өөрөөр хэлвэл бие даасан хоёр талын тайлагнасан дүн нийлсэн бол Засгийн газрын дүн баталгаажиж, төслийн зорилго биелэгдсэн хэмээн тооцно. Энэ тохиолдолд анхан шатны бүртгэлийг шалгах шаардлага үгүй юм.

Компанийн болон Засгийн газрын маягт дээр тусгагдаагүй өөр ямар нэгэн төлбөр Засгийн газарт хийгдсэн эсэхийг баталаажуулахгүй. Тодорхой нэгэн татварын төлбөр болон үүнийг хүлээн авсан талаарх мэдээлэл байхгүй нь тухайн татвар төлөгдөөгүй болохыг илэрхийлэх албагүй бөгөөд энэ тохиолдол болгоныг илрүүлэн гаргах нь бидний үүрэг биш юм. Мөн ийм төрлийн орхигдсон зүйлсийг илрүүлэн олох нь ихээхэн хүндрэлтэй, тухайн компанийн бүх бүртгэлийн талаарх бүрэн мэдээллийг шалгасан ч илрүүлэх нь бараг боломжгүй юм.

Компанийн зүгээс хийсэн төлбөр болон Засгийн газрын хүлээн авсан тайлан дээр зөрүү гарсан бол компанийн зүгээс төлсөн бүх төлбөрийг эргэн баримтаар нь шалгах

нь зөвхөн тийм баримт байгаа эсэхийг баталгаажуулахаас бус ямар шалтгааны улмаас тухайн төлбөр нь Засгийн газрын тайланд тусаагүй болохыг шалган илрүүлэхгүй билээ.

Уул уурхайн компаниудын нягтлан бодох бүртгэл нь өмнө нь аудитын шалгалтаар баталгаажсан болохыг мөн дурдаад олон тооны компаниуд өөрийн удирдлагын мэдээллийг гарган авах, иж бүрэн уул уурхайн үйл ажиллагааг хянах зэрэг зорилгоор эмх цэгцтэй бүртгэлд хөтлөн, байнга аудит хийлгэж байх хэрэгтэй байдаг болохыг дурдаж байна. Зарим компаниуд нь хувьцаа эзэмшигчдийн хяналт дор байдаг ба томоохон хэмжээний үндэстэн дамнасан компаниудын хувьд нягтлан бодох, бүртгэл, тайлан, хяналт, аудит зэрэг нь заавал гүйцэтгэх үүрэг байдаг билээ.

Зөрүү илэрсэн тохиолдолд, тэдгээрийг хянан шийдвэрлэх үйл явц нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- А. Оролцогч тал болгоноос төлбөрийн талаарх нарийвчилсан мэдээллийг авах/ тэдний маягт дээр байгаа төлбөрийг хүлээн авсан болохыг баталгаажуулах. Эдгээр нарийвчилсан мэдээлэл нь төлсөн дүн, төлбөр хийсэн өдөр/ хүлээн авсан өдөр болон төлөгч/хүлээн авагчийн нэрсийг багтаах ёстой.
- Б. Хүлээн авсан мэдээллийг харьцуулан гарч байгаа зөрүүнүүдийг тогтоон тэдгээр зөрүү үүссэн шалтгааныг судлах.

Дээрх дээр үндэслэн бид дараах зүйлсийг гүйцэтгээд байна.

- А. Засгийн газрын зүгээс тайлагнасан болон компанийн зүгээс тайлагнасан маягт нэг бүрийг тулган шалгах
- Б. Компани бүрээр маягтын хэсэг тус бүр дээр зөрүүнүүдийг тогтоох
- В. ОУИТБС-аас зөрүүнүүдийг бага болон их хэмжээний хэмээн ангилах ямар нэгэн шалгуур үзүүлэлтийг гаргаагүй тул бид энэхүү төсөлд зориулан өөрийн тусгай ангилалыг бий болгосон.
- Г. Дээр дурдсан мэдээллүүдийг Засгийн газрын мэдээлэл болон компанийн тайлан, нийт зөрүү болон их хэмжээний зөрүү зэргээр нь нэгтгэн гаргасан.
- Д. Компаниуд болон Засгийн газрыг төлөөлөн тайлан гаргасан ҮТЕГ-аас зөрүү үүсээд байгаа хэсэг болгон дээр нарийвчилсан мэдээллийг гарган өгөхийг хүссэн.
- Е. ҮТЕГ-ын ажилтнуудтай уулзан өөрсдийн хүсэлтийг тавьж ялангуяа НӨАТ болон гаалийн татвар дээр гараад байгаа зөрүүг тайлбарлахыг хүссэн. Эдгээр хоёр хэсэг дээр гараад байгаа системийн асуудлын талаар дурдаж үүнийг мөн өөрсдийн зөрүүний дүн шинжилгээнд тусгасан.
- Ё. Сонгогдсон зарим компанитай биечлэн уулзан өөрсдийн хүсэлтэд хариулт авч Айвенхоу Майнз, Бороо Голд болон Цайрт Минерал компаниудтай холбогдон, уулзаж өөр бусад компаниудтай утсаар болон бусад байдлаар байнга харилцан тэдгээрийн гарган өгсөн мэдээллийн талаар ярилцсан.
- Ж. Дараа, дараагийн уулзалтуудыг ҮТЕГ-тай хийж, тус газраас өгсөн

мэдээллийг нарийвчлан задлан ярилцаж, санал солилцсон.

3. Нэгтгэлийг гаргах явцад гаалийн татвартайгаар хамааралтай үүсээд байгаа асуудлуудын талаар ГЕГ-тай уулзан ярилцсан.

И. Дээр дурдсан ажлуудын хүрээнд болон тэдэн дээр үндэслэн үйл явцын талаарх санал зөвлөмжүүдээ гаргасан.

Дээр дурдсаны дагуу ОУИТБС нь сайн дурын үндсэн дээр нэгдэн ордог, компаниуд, Засгийн газар, хөрөнгө оруулагчид болон иргэний нийгмийн байгууллагуудын дэмжлэг бүхий санаачлага юм. Засгийн газрын төсвийн асуудлаарх ил тод байдлыг сайжруулах өөр бусад үйл ажиллагааны хажуугаар ОУИТБС нь иргэд өөрийн Засгийн газраас дээрх дурдагдсан орлогын зарцуулалтад хариуцлагатай хандахыг шаардах шинэ үйл явцыг эхлүүлж байна.

ОУИТБС-ын зорилт нь ил тод байдлыг сайжруулж, ингэснээр хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэн авлигаас сэргийлэх явдал билээ. Тиймээс энэхүү төсөл нь ил тод, нээлттэй байдалд чухал шаардлагатай мэдээллээр ханган өгөх зорилготой юм. Төсөл нь мөн төлбөрийг буруу зарцуулан удирдсан болон авлигын эх үүсвэр болгосон зэрэг үндэслэлийг гарган ирэх бус харин хариуцлагатай байдлыг бий болгоход туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах зорилготой юм.

Энэхүү нэгтгэсэн аудит нь Монгол улсад хийгдсэн хамгийн анхны нэгтгэл юм. Хэдий хэмжээгээр энэхүү үйл ажиллагааг урьдчилан төлөвлөсөн, энэхүү төлөвлөлт нь хэр сайн явагдсанаас үл хамааран аль ч улсад явагдаж байгаа ижил төрлийн үйл явц нь өөрийн анхны жилдээ төлөвлөлтийн үе шатанд олж хараагүй асуудлуудыг нээн илрүүлэн гаргадаг билээ. Мөн нэгтгэл дээр гарсан зөрүүнүүд нь шийдэгдэх боломжгүй байх явдал гарч болох бөгөөд энэ нь ихэвчлэн энэхүү бүхэл үйл явцад үүсэн гарч буй асуудал, хүндрэлүүдээс хамааран үүсдэгийг тэмдэглэх нь зүйтэй.

Энэхүү анхны нэгтгэлд цөөн тооны компани хамрагдсан нь дээрх асуудлуудаас үүдэн гарсан болохыг тэмдэглэж байна. Зарим талаар энэ анхны нэгтгэл нь туршилтын төсөл байдлаар үнэлэгдэн, тооцогдох бөгөөд энэ талаарх зарим хэт явцуу санал дүгнэлтийг гаргахаас өмнө энэ талыг нь сайтар тунгаан, бодож үзэх нь зүйтэй. Энэ нөхцөлд тухайн үйл явцыг судлан үзэх, тэдгээрийг сайжруулах санал зөвлөмжийг боловсруулах зэрэг нь хамгийн чухал явдал бөгөөд зөвхөн нэгтгэлийн үед гарсан зөрүүний хэмжээгээр төслийн үр дүнг хэмжих боломжгүй юм.

Бүлэг 3: Үйл явц

Мэдээлэл цуглуулах

Компаниудын зүгээс хийсэн төлбөр болон Засгийн газрын зүгээс хураан авсан татвар хураамжийн талаарх мэдээлэл цуглуулах үйл явц нь дараах байдлаар явагдсан болно.

А. Компаниудын зүгээс хийсэн төлбөрүүд

Уул уурхайн салбарт ажиллаж байгаа компаниуд нь өөрсдийн зүгээс Засгийн газрын харьяа байгууллагууд, агентлагуудад төлсөн төлбөрийн талаарх нэгдсэн мэдээг Монголын ОУИТБС-ын Маягт 1-ийн дагуу тайлагнан хүргүүлсэн.

Монголын ОУИТБС нь компаниудын төлбөрийн талаарх мэдээллийг Майкрософт Ексел програмд оруулан компани бүрээр төлбөрийн дүнгүүдийг гаргасан.

Б. Засгийн газрын зүгээс хүлээн авсан төлбөр

Уул уурхайн компаниуд нь өөрсдийн татвар хураамжид төлж байгаа мөнгийг Засгийн газрын бүх түвшинд хийдэг бөгөөд үүний тоонд яам, агентлагууд, орон нутгийн аймаг сумын түвшинд болон сургууль зэрэг орон нутгийн байгууллагуудтай мөн харьцаж төлбөрөө хийдэг юм.

Засгийн газрын харьяа байгууллагууд болон агентлагууд нь уул уурхайн үйл ажиллагаа эрхлэж буй компаниудаас хүлээн авсан татвар, хураамж зэргийг ОУИТБС-ын Маягт 2-ын дагуу дагуу тайлагнах үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү маягт дээр 2006 оны санхүүгийн жилд уул уурхайн компаниудаас хийсэн төлбөрийг компани тус бүрээр нь нарийвчлан гаргах үүрэг хүлээсэн.

Эдгээр маягтуудыг Үндэсний Татварын Ерөнхий Газарт хүргүүлэн нэгдсэн тайлан болгон Маягт 3-ын дагуу компани тус бүрээр нь нэгдсэн тайланг гаргажээ.

Маягт 3-ыг (Засгийн газрын зүгээс компани тус бүрээр гаргасан нэгдсэн тайлан) Санхүү Эдийн Засгийн Яаманд хүргүүлэн баталгаажуулах үйл ажиллагааг мөн эрхлэн явуулсан.

Монголын ОУИТБС-ын зүгээс Засгийн газрын хүлээн авсан төлбөрийн нэгдсэн тайланг Майкрософт Ексел програмд оруулан, компани бүрээр төлсөн төлбөрийг маягтын дагуу гаргажээ.

В. Монголын ОУИТБС-ын Маягт 4

Энэхүү маягт нь уул уурхайн компаниуд өөрийн үйлдвэрлэл, борлуулалт болон ашиг орлогын талаарх мэдээллийг Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газарт тайлагнан улмаар тухайн агентлагийн зүгээс Монголын ОУИТБС-д нэгдсэн тайлан гарган өгөх зорилгоор хэрэглэхээр боловсруулагдсан юм. Монголын ОУИТБС-ын зүгээс бидэнд мэдээлснээр энэхүү үйл явц нь одоогийн байдлаар бүрэн хэмжээгээр хэрэгжиж эхлээгүй байгаа ажээ.

Г. Монголын ОУИТБС-ын зүгээс бидэнд мөн мэдээлсэнээр Маягт дээр багтсан зарим төрөл дээрх мэдээллийг цуглуулахгүй байхаар шийдсэн байна. Эдгээр нь

Татварууд

2.а.9

Хувь хүний орлогын албан татвар

- 2.a.10 Ажил олгогчийн зүгээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- 2.a.11 Ажилтны зүгээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- 2.a.12 Бусад
Бусад татвар мөнгөн дүнгээр

Төлбөр

- 2.6.9 Лицензын төлбөр

Хураамж, үйлчилгээний хөлс

- 2.b.3 Гаалийн хураамж\татвар

Монголын ОУИТБС-ын зүгээс компанийн сайн дурын үндсэн дээр тайлагнасан Маягт-1 ын 2 дугаар хэсэг дээрх ашиг орлогийн мөнгөн урсгалын хэсгийг орхихыг хүссэн болно.

Нэгтгэл

Компаниудын зүгээс төлсөн татвар хураамж болон Засгийн газрын зүгээс тэдгээрийг хүлээн авсан талаарх нарийвчилсан мэдээллийг Монголын ОУИТБС-ын гаргасан нэгдсэн мэдээллээс авч ашиглан тэдгээрийг уул уурхайн компани бүрээр Майкрософт Ексел програм дээр оруулан улмаар компаниудын төлсөн татвар хураамж болон Засгийн газрын зүгээс хүлээн авсан тооны хоорондын зөрөөг тодруулан гаргасан болно.

Бидэнд мэдээлсэнээр Монголын ОУИТБС-ын зүгээс компанийн болон Засгийн газрын хоорондын дүнгийн зөрөөг их болон бага хэмжээний хэмээх ангилалд хамруулаагүй байсан бөгөөд бидэнд хандан мэргэжлийн үүднээс үнэлэлт дүгнэлт өгөн ийм төрлийн ангилалд хамруулах шалгуур үзүүлэлтүүдийг гаргахыг хүсэмжилсэн билээ.

Бидний Гүйцэтгэх ажлын тодорхойлолтод заасанчлан компани тус бүрээр болон нэгдсэн байдлаар тайлан гаргах үүргийн дагуу бид татвар, хураамж болгонд хамаарах ангилалыг ерөнхийлөн гаргаж компаниудаас хүлээн авсан хэмээн Засгийн газрын зүгээс тайлагнаж буй нийт үнийн дүнд гарч буй 5 хүртэлх хувийн зөрүүг нь бага хэмжээний хэмээн тооцсон болно. Гэхдээ бидний зүгээс нийт мөнгөн дүн болон баримтын хэмжээнээс хамааран Эрдэнэт компани дээр өөр үндэслэлийг ашигласан болно. Эрдэнэт компанийн хувьд бид 500,000,000 (эсвэл Засгийн газрын зүгээс Эрдэнэт компаниас хүлээн авсан хэмээн тайлагнасан төлбөрийн 0.14%) болон түүнээс дээш хэмжээний зөрүүг их хэмжээний хэмээн үзсэн болно.

Дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гарч буй зөрүүг бага хэмжээний болон их хэмжээний хэмээн ангилсан юм.

Анхан шатны харьцуулалт

Бүх компаниудын хийсэн төлбөрийн нэгдсэн дүн (Маягт #1) болон Засгийн газрын зүгээс хүлээн авсан төлбөр хураамжийн нийт дүнгийн (Маягт #2) хоорондын зөрүү нь доор нарийвчлан дурдсанчлан 96,826,863 мянган төгрөг болж байна. Үүнд:

Төлбөр болон хүлээн авсан төрлөөр нь хийсэн шинжилгээ

Төрөл	Компанийн зүгээс төлсөн төлбөр (мянган төгрөгөөр)	Засгийн газрын зүгээс хүлээн авсан нийт төлбөр (мянган төгрөгөөр)	Нэгтгэсэн цэвэр зөрүү (мянган төгрөгөөр)
Нийт татвар	333,583,355	324,333,6698	-9,249,687

Нийт төлбөр	60,607,740	42,288,902	-18,318,838
Нийт хураамж	2,211,858	0	-2,211,858
Нийт ногдол ашиг	98,440,436	38,337,637	-60,102,799
Нийт төлбөрүүд	3,012,958	2,671	-3,010,287
Нийт хандив, тусламж	4,236,863	303,469	-3,933,394
Нийт	502,093,210	405,266,347	-96,826,863

Компани бүрээр хийсэн шинжилгээ

Компанийн нэр	Компанийн зүгээс төлсөн төлбөр (мянган төгрөгөөр)	Засгийн газрын зүгээс хүлээн авсан нийт төлбөр (мянган төгрөгөөр)	Нэгтгэсэн цэвэр зөрүү (мянган төгрөгөөр)
Шарын Гол	1,221,763	608,111	-613,652
Багануур	3,461,022	3,558,023	97,001
Чинхуа МАК			
Нарийн Сухайт	2,610,141	874,639	-1,735,502
Айвенхоу Майнз Монголиа Инк	9,433,535	1,558,946	-7,874,589
Цайрт Минерал	4,197,473	5,831,067	1,633,594
Бороо Голд	11,546,790	5,208,579	-6,338,211
Шижир Алт	6,296,953	4,658,998	-1,637,954
Улз Гол	634,622	498,465	-136,157
Жамп	696,604	618,069	-78,534
Коулд Голд	309,511	286,602	-22,909
Шинь Шинь	744,270	15,370	-728,900
Эрдэс холдинг	387,665	317,526	-70,139
Монросцветмет	1,883,080	902,599	-980,481
МАК	1,063,208	767,504	-295,703
Петро Чайна	3,958,905	46,444	-3,912,461
Дацан Трейд	473,738	257,220	-216,518
Алтан Дорнод	6,602,335	3,879,604	-2,722,730
Гацуурт	2,043,194	2,054,916	11,722
Шивээ Овоо	1,076,349	1,039,224	-37,125
Адуунчулуун	263,622	253,810	-9,812
Шим Технологи	324,267	305,197	-19,069
Монгол Газар	77,889	275,364	197,476
Эм-Жи-Эйч	842,884	686,811	-156,073
Тавантолгой	4,266,361	4,451,988	185,628
Эрдэнэтийг оруулаагүй нийт дүн	64,416,179	38,955,077	-25,461,102
Эрдэнэт УБК	437,677,031	366,311,270	-71,365,761
Нийлбэр дүн	502,093,210	405,266,347	-96,826,863

Эдгээр зөрүүтэй дүнгүүдийн талаарх нарийвчилсан шинжилгээг Хавсралт А-д үзүүлсэн болно.

Дээр дурдагдсан цэвэр зөрүүнүүд нь эерэг буюу нэмэх цэвэр зөрөө (Засгийн газрын зүгээс тайлагнасан маягт дээр компанийн зүгээс гаргасан тоотой зөрсөн хэмжээ) болон

сөрөг буюу хасах зөрүү (Компанийн зүгээс тайлагнасан маягт дээр Засгийн газрын зүгээс гаргасан тоотой зөрсөн хэмжээ) харуулж байгаа юм. Нийт эерэг буюу + болон сөрөг буюу - зөрүүний хэлбэлзлийг дараах байдлаар харуулж байна.

Эерэг зөрүү	6,407,478
Сөрөг зөрүү	<u>-103,234,341</u>
	<u>-96,826,863</u>

Дээр дурдсан дүн шинжилгээ нь ихээхэн ноцтой асуудлуудыг үүсгэж байгаа бөгөөд компаниуд нь Засгийн газрын хүлээн авсанаас мөнгөн дүнгээрээ хавьгүй их хэмжээний мөнгийг тайлагнасан байлаа. Энэхүү их хэмжээний зөрүү нь Засгийн газрын хэрэглэж буй маягт нь бүрэн бөглөгдөөгүй, эсвэл үнэн зөв бус, уул уурхайн компаниудын төлсөн бүх татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг болон мөнгөн тусламжийг бүртгэн авч тайлагнаагүй байна.

Тоон дүнгийн зөрүү нь тайлан дээрх бүх л төрөл, зүйл бүрээр илэрсэний хажуугаар ихэнх компанийн хувьд гаалийн татварын хэмжээн дээр зөрүүтэй тоо ихээр гарсан болно. Нийт 23 компаниас өргөн мэдүүлсэн маягтын төлсөн төлбөр болон тэдгээрт хамаарах хүлээн авсан хэмжээ нь хоорондоо нийцэхгүй байлаа.

Компани болгон дээр гарсан зөрүүг дээр дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу бага хэмжээний болон их хэмжээний хэмээн ангилсан. Энэхүү үндэслэлээр дээрх нэгдсэн тайланд дурдсан тоо хэмжээнээс 95,094,967 мянган төгрөгийн цэвэр зөрүү нь их хэмжээний хэмээх ангилалд багтсан ба 1,731,896 буюу 1,79% нь бага хэмжээний хэмээх ангилалд багтах болжээ. Хавсралт Б.

Доор дурдагдсан 3 компанийн хувьд их хэмжээний зөрүү байгаагүй болно. Үүнд:

Багануур
Коулд Голд
Адуунчулуун

Зөрүүг тодруулан шинжлэх нь

Илрээд байгаа зөрүүнүүд дээр дүн шинжилгээ хийж эхлэхээс өмнө бид гаалийн татварын хэсэг дээр ихээхэн системтэй асуудал үүсээд байгаа болохыг ажигласан юм. Тийм учраас бид УТЕГ-ынхантай уулзан энэхүү асуудлаар дахин хянан шалгах, үүн дээр ямар үйл явцын улмаас их хэмжээний зөрүү үүсээд байгаа эсэхийг нягтлаж өгөхийг хүсэмжилсэн юм. Энэхүү уулзалтаар бид мөн НӨАТ дээр байгаа хэд хэдэн томоохон хэмжээний зөрүүнүүдийг мэдээлэн эдгээрт хамаарах тайлбарыг гарган өгөхийг хүсэмжилсэн болно.

Их хэмжээний зөрүү илэрсэн нийт 22 компанид Монгол хэл дээр орчуулсан факсыг илгээн тухайн их хэмжээний зөрүү болгон дээр нарийвчилсан мэдээллийг хүргүүлэхийг хүсэмжилж компани бүрээс тухайн төлбөрүүдийг хийсэн өдөр, хэмжээ, хүлээн авагчийн нэр зэргийг бидэнд гарган өгч дээрх их хэмжээний зөрүүг шалган шийдвэрлэхэд тусалцаа үзүүлэхийг хүссэн.

Үүний ижил факсыг мөн УТЕГ-т илгээн дээр дурдсан компани болгон дээр үүсээд байгаа зөрүүнүүдийн талаарх тайлбарыг бидэнд ирүүлэхийг хүссэн болно.

2008 оны 1 сарын 14-ны өдөр төлөвлөгдсөн ОУИТБС-ын Ажлын хэсгийн уулзалтын өмнө тайланг анхан шатны түвшинд бэлтгэх, үүнийг Монгол хэл дээр орчуулан гаргах зэрэг үйл ажиллагаанд тодорхой цаг гаргах зорилгоор бидний зүгээс 2008 оны 1 сарын

9-ны өдрөөс хойш ирсэн ямар нэгэн хариу болон тодруулгыг Ажлын хэсэгт зориулсан тайланд тусгахгүй байхаар шийдсэн юм.

Тодорхой тооны компаниудаас хариулт хүлээн авсан ч гэсэн зарим компаниуд ялангуяа УТЕГ-аас бидэнд ямар нэгэн хариулт, нэмэлт тодруулга ирүүлээгүй байсан нь эдгээр баримтууд нь 2008 оны 1 сарын 14-ны өдрийн нэгтгэлийн тайлан дээр багтаж орохгүйд хүрсэн юм. Улмаар бид хариулт ирээгүй байгаа компаниудтай эргэн холбоо барьж тодруулга хүсэх болон 2008 оны 1 сарын 7-ны өдөр УТЕГ-тай дараагийн уулзалтыг зохион байгуулж их хэмжээний зөрүү илэрсэн компаниудын мэдээллийг шалгах үйл явцын талаар судлан үзсэн. Энэхүү уулзалтаар бидний хүсэлтийн хариунд ямар зүйл хийж байгаа болохыг судлан маш бага хэмжээний зүйлс хийгдээд байгааг мэдсэн билээ. Энэхүү үйл явцыг түргэсгэхийн тулд бид УТЕГ-т өөрсдийн гаргасан компани тус бүрээрх тайланг өргөн барьсан болно. Энэхүү уулзалтаар Засгийн газрын маягтыг нягтлан шалгасан эцсийн тайланг 2008 оны 1 сарын 10 гэхэд бидэнд ирүүлэх болохыг баталгаажуулсан бөгөөд энэ нь хүлээн авахад хэцүү шахуу хугацаа байсан ч гэсэн бидний зүгээс өөр сонголт байгаагүй болно. Бид мөн гаалийн татварын талаарх асуудлыг ГЕГ-аас тодруулж болох талаар мэдээлэл авсан билээ.

2008 оны 1 сарын 9-ны өдөр Монгол улсын ГЕГ-ын холбогдох хүмүүстэй уулзсан. Гаалийн албаныхан гаалийн татвар, НӨАТ болон онцгой татварыг хэрхэн ноогдуулан хураадаг талаарх мэдээллийг бидэнд өгөн үүний хажуугаар өөрийн үзүүлдэг гаалийн баталгаат агуулахын үйлчилгээний хураамжын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгсөн.

Үүсээд байсан зөрүүнээс хараад бидний ажиглалтаар гаалийн газраас үйлчилгээний хөлсийг татварт багтаан тооцдоггүй тул энэ баримтаас үүдэн зарим хэмжээний зөрүүнүүд үүсээд байгаа болохыг илрүүлсэн. Зарим компаниуд нь энэ төрлийн үйлчилгээний хураамжийг татвар хэмээх хэсэг дээр нэмэн тайлагнасан байсан нь мэдэгдсэн.

Гаалийн татварын хэсэг дээр илэрсэн зөрчлүүдийг тусгайлан тэмдэглэсэн тайланг ГЕГ-т гарган өгсөн бөгөөд тус газраас 2008 оны 1 сарын 11-ны өдрийн үдээс хойш нягтлан шалгасан тайланг гарган өгөхөөр болсон.

2008 оны 1 сарын 10-ны өдөр бид УТЕГ-ын ажилтнуудтай дахин уулзаж ярилцсан бөгөөд энэ үеэр тус газраас бидэнд томоохон хэмжээний мэдээлэх хуудсыг өгсөн юм. Энэхүү материалд бидний хүсэлтэд дурдсан мэдээллийг бүрэн агуулаагүй ч, Засгийн газрын мэдээлэлтэй холбоотой зарим мэдээлэл багтсан байсан юм. Хамгийн чухал нь тухайн материал нь зөвхөн их хэмжээний зөрүү илэрсэн хэсгүүдэд хамаарах мэдээллийг өгөөд зогсохгүй бидний 2007 оны 1 сарын 7-ны өдөр гаргасан тайлан дээрх бүх компанийн тайлантай холбоотой мэдээллүүд мөн байсан юм.

УТЕГ-ын гаргасан материалаас үзвэл өмнө нь Засгийн газрын маягт дээр тусгагдан тайлагнасан олон дүн хэмжээнд засвар хийж өөрчилсөн байлаа. Эдгээр өөрчлөлтүүд нь их хэмжээний зөрүү илрээд байсан зарим зөрүүг тайлбарлаад зогсохгүй, бага хэмжээний зөрүүтэй болон огт зөрүүгүй байсан зарим зүйлс дээр ч гэсэн ихээхэн өөрчлөлтийг оруулахад хүргэсэн юм.

УТЕГ-аас гарган өгсөн материал бидэнд Засгийн газрын тайлан дээр байгаа бүх компанийн төлбөр бүрийг эргэн шалгах шаардлагыг үүсгэсэн. Хэдийгээр зарим нэгэн их хэмжээний зөрүү нь шийдэгдсэн ч (зарим нь их хэмжээнээс бага гэсэн ангилалд орох гэх мэт) гэсэн, өмнө нь бага хэмжээний байсан зүйлс дээр шинээр их хэмжээний зөрүүнүүдийг үүсгэх хүндрэлийг учруулсан.

Хоёрын зэрэг компаниас хүлээгдэж байсан хариултауд нь 2008 оны 10 болон 11-нд өөр нэгэн компанийн хоёрдахь удаагийн тодруулгатай хамтаар бидэнд ирсэн бөгөөд эдгээр

хариун дээр тэрхүү компаниудын өмнө нь тайлагнасан байсан дүн хэмжээ нь ихээхэн хэмжээгээр өөрчлөгдсөн байлаа.

ГЕГ-аас авах ёстой мэдээллийг 2008 оны 1 сарын 11-ны өдөр бүрэн хэмжээгээр хүлээн авсан. Энэхүү ГЕГ-аас өгсөн мэдээлэл нь ҮТЕГ болон Засгийн газрын зүгээс тайлагнан гаргасан аль ч маягтын тоон дүнтэй нийцэхгүй байсан ч хоёрын зэрэг их хэмжээний зөрүүний учир шалтгааныг тодруулан гаргаж өгсөн болно.

Дээд хэсэг дээр дурдагдсан асуудлуудаас үүдэн гарсан их хэмжээний нэмэгдэл ажлаас шалтгаалан 2008 оны 1 сарын 14-нд хуралдсан ОУИТБС-ын Ажлын хэсгийн хуралд бүрэн хэмжээний тайланг өргөн мэдүүлэх боломжгүй болоод байсан билээ. Үүний улмаас бид анхан шатны бүрэн бус хэмжээний тайланг гарган гишүүдэд тараах хэрэгтэй болсон бөгөөд энэ талаарх бүх мэдээллийг тухайн тайлангын нүүр хуудсан дээр дурдсан болно. Тэр анхан шатны тайлан нь зөвхөн үүсээд байгаа зөрүүнүүдийг тодорхойлсон тайлан байсан ба тусгагдаад байсан санал зөвлөмж нь тухайн үедээ эцэслэн боловсруулагдаагүй байсан болно.

Бүлэг 4: Тодруулга

Нэгтгэсэн зөрүү

ҮТЕГ-аас Засгийн газрын тайланд багтаан мэдээлсэн өөрчлөлтүүд болон компаниудын зүгээс хийсэн өөрчлөлт зэргийг шинээр тооцоолон тусгасны дараагаар нэгтгэсэн зөрүүний хэмжээ нь доорх байдлаар гарлаа.

	Маягт	Тодотгол	Баланс
Засгийн газрын хүлээн авсан хэмжээ	405,266,347	61,927,252	467,193,600
Компанийн төлсөн хэмжээ	-502,093,210	9,805,457	-492,287,753
Зөрүү	-96,826,863	71,732,709	-25,094,153

Энэхүү өөрчлөлтүүдийн талаарх нэгтгэсэн мэдээллийг Хавсралт Г-гээс үзнэ үү.

Татвар төлбөрүүд

Доор дурдсан мэдээллүүд нь маягт дээр дурдагдсан байгаа бие даасан татвар, мөр, хэсэг болгоныг сонгон авч тухайн хэсэг дээрх нийт дүнг нэгтгэн, үүнээс үүдсэн их хэмжээний зөрүү, болон тэдгээрийн учир шалтгаан зэргийг бүрэн агуулсан дүгнэлт, тойм хэсэг болно. Компани болгоны төлсөн мөнгө, тухайн төлбөрийг хүлээн авсан байдал болон зөрүүнүүд нь шийдэгдсэн болон шийдэгдээгүй эсэхийг компанийн тайлан болгоноор нь тусгай хавсаргасан ба тухайн тайлангуудыг энэхүү тайлангийн нэгэн бүрэлдхүүн хэсэг хэмээн үзэж болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	-132,122,838	- 464,433	-132,587,271
Засгийн газар	<u>134,635,576</u>	<u>7,725</u>	<u>134,627,851</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>2,512,738</u>	<u>- 472,158</u>	<u>2,040,580</u>

Энэхүү хэсэг дээр үлдсэн шийдэгдээгүй хамгийн гол асуудал нь НӨАТ-ын буцаан авалтын өрийг орлогын албан татвар болон бусад татварт суутган тооцох явдал байлаа. ОУИТБС-ын маягт дээрх зааварчилгаанууд нь энэ талаар нарийн тодорхой мэдээлэл, зааварчилгааг хангаж өгөөгүйн улмаас компанийн зүгээс гаргасан тайлан болон татварын албаны зүгээс гаргасан тайлангын хооронд ихээхэн хэмжээний зөрүү үүссэн байна. Өөрөөр хэлбэл компани болгон өөр өөрийн үзэмжээр энэ хэсэг дээр хандах болоод байна. Компаниудын зүгээс ирсэн хариулт тодотголууд болон тэдэнтэй уулзан ярилцсанаас үзвэл зарим компаниуд нь энэ мэтийн шилжүүлэн тооцолт явагддаг талаар мэдэхгүй, мөн өөрсдийн НӨАТ-ын буцаан авалт нь хэд байгааг сайтар мэдэхгүй, мэдээлэлгүй байх явдал ч байлаа.

Буцаан авсанаа хассан НӨАТ

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	-12,708,669	7,022,136	-5,686,533
Засгийн газар	<u>4,263,985</u>	<u>0</u>	<u>4,263,985</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-8,444,684</u>	<u>7,022,136</u>	<u>-1,422,548</u>

Дотоодын зах зээл дээрээс бараа, үйлчилгээ худалдан авахдаа уул уурхайн компаниуд НӨАТ төлдөг байна. Гэхдээ энэ нь зөвхөн дотоодын худалдан авалтаар хязгаарлагдах бус харин бараа импортоор оруулж ирж байгаа нөхцөлд НӨАТ-ыг гаальд төлсөнөөр өөрийн барааг хүлээн авдаг байна. Ашигт малтмал экспортод гаргадаг компаниудын хувьд НӨАТ-ын авлага буюу буцаан авсан үүсдэг бөгөөд энэ шалтгааны улмаас уул уурхайн компаниуд нь их хэмжээний цэвэр НӨАТ-ын тэнцэлтэй байдаг ажээ. Бусад төрлийн татвараар (жишээ нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон зарим барааны үнийн өсөлтийн албан татвар зэрэг) ногдуулсан хэмжээг энэхүү хуримтлагдсан авлагаар хааж болдог байна.

Компаниудын зүгээс тайлагнасан маягт дээр дурдагдсан зарим их хэмжээний зөрүүний учир шалтгааныг ялангуяа орон нутгийг бараа үйлчилгээг худалдан авалттай холбоотой НӨАТ-ын асуудлуудыг шалган шийсэн болно. Энэ тохиолдол дээр компанийн маягт дээр харуулсан мөнгөн дүн нь буурсан бөгөөд учир нь тэдгээр төлбөрүүд нь Зсгийн газарт бодитоор төлөгдөөгүй төлбөрүүд юм.

Компани болгон дээр НӨАТ-ыг тайлагнахдаа чухам ямар хэсгийг нь тайлагнах тал дээр алдаа гаргасан зүйлс байсан бөгөөд эдгээрийг цаашдын үйл ажиллагаанд анхаарах хэрэгтэй байна. Эдгээрийг жишээгээр үзүүлбэл:

- Бороо Голд компаниас тайлагнасан маягтад дурдсанаар 4,647,936 мянган төгрөгийг 2006 оны ирээдүйд төлөх НӨАТ-ын авлагад тооцсон байна.
- Цайрт Минерал компанийн тайлагнасан 983,105 мянган төгрөг нь дотоодын бараа үйлчилгээг худалдан авахдаа төлсөн НӨАТ-ыг багтаажээ. (Үүнийг дээр дурдсан тодруулгад багтаасан болно)

Тухайн жилийн хугацаанд тэдгээр компаниуд нь НӨАТ-ыг бодитоор төлөөгүй бөгөөд энэ талаар Засгийн газрын зүгээс гаргсан маягтад дурдсан байлаа.

Зарим компаниуд нь НӨАТ-ын хэмжээг дурдахдаа импортоор оруулж ирсэн бараанд төлсөн НӨАТ, онцгой татвар болон гаалийн татвар зэргийг нэгтгэн тайлагнасан байсан ба нэгдсэн бүх дүнг нь гаалийн татвар хэмээн тайлагнасан тохиолдол байна.

ОУИТБС-ын маягтууд дээрх зааварчилгаанууд нь энэхүү НӨАТ-тай холбоотой зүйлсийг хэрхэн тайлагнах талаарх тодорхой мэдээллийг оруулаагүй байсан ба үүний улмаас компаниуд өөр өөрөөр мэдээлэх, мөн компаниуд болон татварын албаны хооронд энэ хэсэг дээр ямар зүйлсийг багтаах талаар маргаантай асуудал байлаа.

Гаалийн татвар

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	9,056,172	269,281	- 8,786,891
Засгийн газар	<u>6,860,924</u>	<u>1,591,768</u>	<u>8,452,692</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-2,195,248</u>	<u>1,861,049</u>	<u>- 334,199</u>

Их хэмжээтэй хэмээх ангилалд багтсан зөрүүнүүд нь олонх компани дээр үүссэн байна. Хэдийгээр нийт зөрүү нь бага мэт санагдавч ихэнх компани дээр эерэг болон сөрөг зөрүүнүүд гараад байна. Хавсралт Д.

5%- ийн гаалийн татвар, 15%- ийн НӨАТ (2007 оноос эхлэн 10% болж буурсан) болон онцгой татварыг бараа бүтээгдэхүүн импортоход ноогдуулж байна. Гаалийн мэдүүлэг нь гаалийн байгууллагад төлсөн энэхүү гурван татварын хэмжээг ялган, зааглаж тэмдэглэсэн байдаг ажээ. Дээрх бүх татварыг тухайн бараа бүтээгдэхүүнийг гаалиас

авахаас өмнө төлж дуусгах ёстой ажээ. Үүний дараагаар гаалийн байгууллагаас НӨАТ-ын хэмжээг Татварын албанд мэдэгддэг байна.

ГЕГ нь үүний хажуугаар гаалийн баталгаат агуулахыг ажиллуулдаг бөгөөд гаалийн бүрдүүлэлт хийхээс мөн бараа бүтээгдэхүүнийг хадгалах үүрэгтэй. Энэхүү агуулахад хадгалуулсан бараанд компаниуд үйлчилгээний хураамж төлдөг бөгөөд гаалийн байгууллагийн мэдэгдсэнээр энэхүү хураамжийг Засгийн газарт тайлагнаж байгаа татварын мэдээнд багтаадаггүй байна. Их хэмжээний зөрүүний талаарх бидний хүсэлтэд гаалийн байгууллагаас зохих хариултыг өгсөн боловч зарим компанийн зүгээс энэхүү хураамжийг өөрсийн маягт дээр тайлагнасан байлаа.

Хэд хэдэн компанийн зүгээс гаалийн ерөнхий газарт төлсөн бүх төлбөрийг (Гаалийн татвар, НӨАТ болон онцгой татвар зэрэг) гаалийн татвар хэмээх хэсэгт багтаасан байлаа. Гаалийн байгууллагаас бидэнд мэдэгдсэнээр гаалийн байгууллагад татвар хэлбэрээр төлж байгаа бүх мөнгөн дүнг зааглан салгаж бараа хүлээн авагчид олгож байгаа гэрчилгээн дээр бичилт хийдэг байна. Зарим компани нь гаальд төлсөн мөнгөн дүнг татвар тус бүрээр нь гаргах боломжгүй хэмээн мэдэгдсэн бөгөөд үүний шалтгааныг тэд гаальд зөвхөн мэдүүлэг гарган өгч харин гаалийн газар өөрөө хариуцан татвар бүр дээр хувиарлалт хийдэг хэмээн мэдэгдэж байлаа. Үүний улмаас зарим компани нь гаалийн байгууллагад төлсөн хэмжээгээ гаалийн татвар хэмээх ангилалд багтаан тайлагнаж, тухайн татвар бүрээр нь нарийвчлан гаргахаас зайлсхийж байлаа.

Зарим компаниуд нь өөрсдийн нягтлан бодох бүртгэл дээр дээрх татваруудыг татвар тус бүрээр нь хувиарлан бүртгэсэн боловч маягт дээр тайлагнахдаа бүх татварын нийт дүнг гаалийн татвар хэмээн тайлагнаж байсан нь тэд маягтыг хэрхэн бөглөх талаар тодорхой мэдлэггүй байсантай холбоотой байж болохоор байна.

ОУИТБС-ын маягтуудын зааварчилгаа нь энэхүү гаалийн байгууллага дээр төлдөг төлбөрийг хэрхэн ялган зааглахыг сайтар тайлбарлаагүй, зааварчилгаа өгөөгүйн улмаас компаниудын зүгээс болон гаалийн, татварын албаны зүгээс ч энэ тал дээр эргэлзээ үүсэх нь их байна.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	176,235,102	- 225,085	- 176,460,187
Засгийн газар	175,944,943	210,462	176,155,405
Нэгтгэсэн цэвэр зөрүү	-290,159	- 14,623	- 304,782

Их хэмжээний зөрүү зөвхөн 2 компани дээр гарсан болно. Эдгээр зөрүүг тэр даруйд нь тогтоон шийдэж үүний улмаас үүдээд байсан зөрүү нь их хэмээх ангилалаас бага хэмжээний ангилалд шилжих болсон.

Үл хөдлөх хөрөнгийн татвар

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 1,679,583	- 2,948	- 1,682,531
Засгийн газар	1,624,228	18,370	1,642,598
Нэгтгэсэн цэвэр зөрүү	-55,355	15,422	- 39,933

Энэхүү хэсэг дээр илэрсэн зөрүү нь нийт дүнгийн хувьд их биш байсан тул үүнийг нягтлан шалгах үйл ажиллагаа хийгдээгүй болно. Гэхдээ тодруулга хийх явцад зарим өөрчлөлт, тодруулга гарсан ч гэсэн энэ нь нийт дүнд ихээр нөлөөлөөгүй болно.

Онцгой татвар (шатах, тослох материал импортлосон бол)

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	-2,007	- 312,563	- 314,570
Засгийн газар	<u>874,567</u>	<u>0</u>	<u>874,567</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>872,560</u>	<u>- 312,563</u>	<u>559,997</u>

Энэхүү хэсэг дээр хийсэн тодотгол нь нэг компанийн маягт дээр орхигдсон байсан дүнгээс үүдэлтэй байлаа. Үлдэж байгаа их хэмжээний зөрүүний дийлэнх хэсэг нь Эрдэнэт компанид хамаарах бөгөөд тухайн компанийн зүгээс ямар нэгэн тодруулга хийгээгүй бөгөөд энэ шалтгаанаа маш их ажлын ачаалалтай байгаагаас хамааран хийх боломжгүй хэмээн мэдэгдсэн болно.

Онцгой татварыг ГЕГ хураан авдаг ба энэ нь мөн дээр дурдагдсан гаалийн татвартай холбоотой ээдрээ эргэлзээг мөн үүсгэдэг байна.

Авто бензин, дизелийн түлшний албан татвар

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	-1,696,814	589,164	-1,107,650
Засгийн газар	<u>45,101</u>	<u>0</u>	<u>45,101</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-1,651,713</u>	<u>589,164</u>	<u>-1,062,549</u>

Энэ хэсэг дээр хийсэн гол засвар тодруулга нь нэг компаниас үүдэлтэй бөгөөд тухайн компани нь өөрийн маягт дээр буруу дүнг оруулсан байснаас шалтгаалсан. Үлдэж байгаа шийдэгдээгүй их хэмжээний зөрүү нь өөр нэгэн компанитай холбоотой бөгөөд ажлын ачааллаас хамааран энэ талаар ямар нэгэн тодруулга өгөх боломжгүй болохоо тус компани мэдэгдсэн юм.

Авто тээвэр, өөрөө явах хэрэгслийн албан татвар

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 84,177	- 633	- 84,810
Засгийн газар	<u>84,345</u>	<u>9,768</u>	<u>94,113</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>168</u>	<u>9,135</u>	<u>9,303</u>

Энэхүү хэсэг дээр гарсан бүх зөрүү нь харьцангуй бага хэмжээтэй байсан бөгөөд эдгээр нь тухайн компани бүр дээр гаргасан нарийвчлалын түвшнээс бага байсан болно. Ийм учраас энэ талаар тодруулах ямар нэгэн үйл ажиллагаа хийгдээгүй болно. Харин УТЕГ-аас өөрийн гаргасан тайланд хамаарах зарим нэг жижиг хэмжээний засварыг хийж ирүүлсэн.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 39,452,649	- 232,195	- 39,684,844
Засгийн газар	<u>39,047,996</u>	<u>-465,527</u>	<u>38,582,469</u>

Нэгтгэсэн цэвэр зөрүү -404,653 - 697,722 - 1,102,375

Компаниудын хийсэн энэ төрлийн төлбөрийн асуудлаар гарсан хамгийн гол тодруулга нь нэг компанийн зүгээс өөрийн төлсөн мөнгөн дүнг сүүлд нь засварлан ирүүлсэнээс үүдсэн ба тус компани нь энэ талаараа өмнөх анхны тайландаа дурдахаа мартсан байсанд оршино.

Засгийн газрын хүлээн авсан төлбөрийн хэмжээн дээр хийсэн тодруулгаар ҮТЕГ нь Засгийн газрын зүгээс тайлагнасан их хэмжээний мөнгөн дүн нь О хэмжээтэй байх ёстойг эргэн мэдэгдсэн. Мөн дээр дурдсаны адилаар өөр нэгэн компани нь өөрийн О хэмжээтэй байсан төлөлтийг нилээд их хэмжээгээр нэмэгдүүлэн тодруулга хийсэн билээ.

Нийт төлбөрийн хэмжээнд энэхүү татварын эзлэх хувь хэмжээ нь харьцангуй бага боловч энэхүү татварыг тооцолоход ихээхэн эргэлзээтэй, ээдрээтэй үйл явцыг туулдаг болох нь ил байна.

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 7,871,541	-164,874	- 8,036,415
Засгийн газар	<u>314,810</u>	<u>0</u>	<u>314,810</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-7,556,731</u>	<u>-164,874</u>	<u>- 7,721,605</u>

Энэ хэсэг дээр гарсан их хэмжээний зөрүү нь Засгийн газраас тайлагнасан маягтад дээрх төлбөрийг хүлээн авсан эсэхийг тусгаагүй байсантай холбоотой байлаа.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 1,207,176	- 686,776	- 1,893,952
Засгийн газар	<u>0</u>	<u>0</u>	<u>0</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-1,207,176</u>	<u>-686,776</u>	<u>- 1,893,952</u>

Энэхүү хэсэг дээр гарсан их хэмжээний зөрүү нь Засгийн газрын зүгээс өөрийн маягт дээр компаниудын хийсэн төлбөрийг хүлээн авсан талаараа тайлагнаагүйн улмаас үүдэн гарсан.

Газрын төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 7,587,980	16,749	- 7,571,231
Засгийн газар	<u>302,949</u>	<u>41,286</u>	<u>344,235</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-7,285,031</u>	<u>58,035</u>	<u>- 7,226,996</u>

Энэхүү хэсэг дээр гарсан их хэмжээний зөрүү нь Засгийн газрын зүгээс өөрийн маягт дээр компаниудын хийсэн төлбөрийг хүлээн авсан талаараа тайлагнаагүйн улмаас үүдэн гарсан.

Ус ашигласны төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	-2,058,516	- 30,673	-2,089,189
Засгийн газар	<u>1,789,933</u>	<u>-179,729</u>	<u>1,610,204</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-268,583</u>	<u>-210,402</u>	<u>-478,985</u>

Энэ хэсэг гарсан зөрүү нь хэд хэдэн компани дээр үүссэн бөгөөд энэхүү зөрүү нь голдуу бага хэмжээний хэмээх ангилалд багтаж байсан билээ. Мөн Засгийн газрын зүгээс өөрийн хүлээн авсан төлбөрийн талаар тайлагнаагүй нь энэ хэсэг дээр зөрүү үүсэхэд нөлөөлсөн юм.

Ойгоос мод түлээ бэлтгэсний төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 100	-684	- 784
Засгийн газар	<u>200</u>	<u>0</u>	<u>200</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>100</u>	<u>-684</u>	<u>- 584</u>

Энэ хэсэг дээр илэрсэн зөрүүний хэмжээ нь бага хэмжээний хэмээх ангилалд багтах тул дахин тодруулах үйл ажиллагаа хийгдээгүй болно.

Гадаадын мэргэжилтэн ажилчны ажлын байрны төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 2,424,185	-48,467	-2,472,652
Засгийн газар	<u>813,772</u>	<u>0</u>	<u>813,772</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-1,610,413</u>	<u>- 48,467</u>	<u>- 1,658,880</u>

Энэхүү хэсэг дээр гарсан их хэмжээний зөрүү нь Засгийн газрын зүгээс өөрийн маягт дээр компаниудын хийсэн төлбөрийг хүлээн авсан талаараа тайлагнаагүйн улмаас үүдэн гарсан.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 5,594	-2,875	- 8,469
Засгийн газар	<u>19,241</u>	<u>2,052</u>	<u>21,293</u>
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>13,647</u>	<u>- 823</u>	<u>12,824</u>

Энэ хэсэг дээр илэрсэн зөрүүний хэмжээ нь бага хэмжээний хэмээх ангилалд багтах тул дахин тодруулах үйл ажиллагаа хийгдээгүй болно.

Зохих хууль, тогтоомжын дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 44,014	217	- 43,797
Засгийн газар	<u>0</u>	<u>0</u>	<u>0</u>
Цэвэр нэгтгэсэн зөрүү	<u>-44,014</u>	<u>-217</u>	<u>-43,797</u>

Энэхүү хэсэг дээрх зөрүү нь бага хэмжээний хэмээх ангилалд багтаж байсан тул энэ талаар тодруулах ажил хийгдээгүй болно. Гэхдээ зөрүү гарч байгаа нөхцөл байдлаас үзэхэд энэхүү төлбөр, хураамжийн талаарх мэдээллийг Засгийн газрын маягтад оруулаагүй байсан байж болно.

Зохих хууль, тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 612,958	- 17,823	- 630,781
Засгийн газар	0	0	0
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-612,958</u>	<u>- 17,823</u>	<u>-630,781</u>

Энэхүү хэсэг дээр гарсан их хэмжээний зөрүү нь Засгийн газрын зүгээс өөрийн маягт дээр компаниудын хийсэн төлбөрийг хүлээн авсан талаараа тайлагнаагүйн улмаас үүдэн гарсан.

Гаалийн үйлчилгээний хураамж

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 1,554,886	0	1,554,886
Засгийн газар	0	1,554,886	1,554,886
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-1,554,886</u>	<u>1,554,886</u>	<u>0</u>

Энэхүү хэсэг нь Чинхуа МАК компаниас Хятад улс руу нүүрс тээвэрлэхэд үзүүлсэн үйлчилгээний хөлсийг багтаасан юм. ГЕГ-аас гаргасан мэдээлэлд энэ талаар дурдагдаагүй байсны учир нь тус газраас энэ төлбөрийг татвар биш харин үйлчилгээний хураамж хэмээн үзсэнд оршино. Харин ГЕГ-аас гаргасан мэдээлэл дээр Чинхуа МАК компаниас төлбөр авсан болохыг дурдсан байсан тул энэхүү зөрүүг тухайн компанид тогтоосон нарийвчлалын түвшний хүрээнд шийдсэн болно.

Төрийн өмчийн ногдол ашиг

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 97,408,079	950,000	-96,458,079
Засгийн газар	38,337,637	58,119,284	96,456,921
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-59,070,442</u>	<u>59,069,284</u>	<u>1,158</u>

Эрдэнэт компани нь 2006 оны 12 дугаар сарын 29- ны өдөр төрийн өмчийн ногдол ашиг болох 59,152,701 мянган төгрөгийг шилжүүлсэн нь хүлээн авагч талын дансанд 2007 оны 1 сарын 2- нд орсон учраас үүнийг 2007 онд хүлээн авсан төлбөр хэмээн үзэж Засгийн газрын зүгээс гаргасан 2006 оны маягтад тусгаагүй байна.

Шижир Алт компани нь өөрийн өргөн мэдүүлсэн маягтаа 950 000 000 төгрөгийн ногдол ашгийг дурдсан байсан ч энэ нь Засгийн газарт бус харин өөрийн хувьцаа эзэмшигч Монголросцветмет компанид олгосон ногдол ашиг байсан.

Засгийн газрын маягт нь төрийн өмчийн ногдол ашгийн 1,032,357 төгрөгийг тусгасан байсан ч, Таван толгой компани нь энэхүү төлбөрийг орон нутгийн өмчийн ногдол ашиг хэмээн тусгасан байна. Гэхдээ энэ талаар тухайн компанийн хамруулсан ангилал нь зөв болохыг өөрсдийн тодруулгаар баталгаажуулсан. (Доорх орон нутгийн өмчийн ногдол ашиг хэсгийг үзнэ үү)

Орон нутгийн өмчийн ногдол ашигт

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	1,032,357	0	-1,032,357
Засгийн газар	0	1,032,357	1,032,357
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-1,032,357</u>	<u>1,032,357</u>	<u>0</u>

Компанийн зүгээс өргөн мэдүүлсэн маягтад орон нутгийн өмчийн ногдол ашиг болох 1,032,357 төгрөгийг дурдсан ч Засгийн газрын зүгээс үүнийг төрийн өмчийн ногдол ашиг хэмээн үзсэн байлаа. Гэхдээ энэ талаар тухайн компанийн хамруулсан ангилал нь зөв болохыг өөрийн тодруулгаар баталгаажуулсан болно.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр

	Маягт	Тодотгол ба өөрчлөлт	Баланс
Нэгтгэсэн төлбөр / хүлээн авсан хэмжээ			
Компани	- 3,010,951	3,007,940	- 3,011
Засгийн газар	2,671	0	2,671
Нэгтгэсэн цэвэр зөрүү	<u>-3,008,280</u>	<u>3,007,940</u>	<u>-340</u>

Энэхүү хэсэг дээрх дүн нь Петро Чайна компанид хамаарч байгаа. Компанийн зүгээс энэхүү тоон дүнг шалган 3,011 мянган төгрөгийг баталсан бөгөөд Засгийн газрын зүгээс гарган тайлангаас ердөө 340 мянган төгрөгийн зөрүүтэй байлаа.

Хандив, тусламж

Хандив, тусламжийн талаар компаниуд болон Засгийн газрын зүгээс гаргасан нэгтгэсэн тоон үзүүлэлтүүдийг доор харуулав.

	Засгийн газрын тайлагнасан төлбөр (мянган төгрөгөөр)	Тодруулга	Хийгдсэн тодруулга, залруулга (мянган төгрөгөөр)
Компаниас яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	1,923		1,923
Компаниас аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	43,172		43,172
Компаниас сумдад үзүүлсэн мөнгөн дэмжлэг	41,176	1,600	41,176
Компаниас орон нутгийн байгууллагад үзүүлсэн мөнгөн дэмжлэг	109,834	74,248	109,834
Компаниас орон нутгийн харилцаа, тогтвортой хөгжилд зарцуулсан хөрөнгө	107,363	11,025	107,363
Нийт хандив, дэмжлэг	303,468	86,909	303,468
	Компанийн маягтууд		
Нийт	-4,236,862	140,000	-4,096,863

Цэвэр дүн	-3,933,395	140,000	-3,793,395
-----------	------------	---------	------------

Засгийн газрын нэгтгэсэн тайланд хийсэн өөрчлөлт нь Эм Жи Эйч компанийн тайлагнасан мөнгөн дүнг өмнө нь орхигдуулсан байсантай холбоотой. Харин компанийн төлбөрийн хувьд хийгдсэн томоохон өөрчлөлт нь Чинхуа МАК компанийн 140,000 төгрөгийн асуудал байсан юм.

Компаниудын зүгээс өргөн мэдүүлсэн тайланд дурдагдсан ихээхэн хэмжээний хандив, тусламжууд Засгийн газрын зүгээс гаргасан маягт дээр дурдагдаагүй байна. Үүнд:

- Компаниуд болон Засгийн газрын зүгээс гаргасан аль ч тайланд хандив, тусламжийн талаар дурдагдаагүйгээс түүнчлэн Засгийн газрын зүгээс гурван компани дээр л энэ талаар дурдаж, Засгийн газар болон компани хоёрын тайлан зөвхөн нэг компани дээр л нийцэж байлаа.
- Засгийн газар болон компанийн маягтууд нийцэж байсан тохиолдол нь зөвхөн цөөн тооны зүйл дээр харагдаж байлаа. Маш олон тооны компанийн маягт дээр олон тооны зөрүү, хандив тусламж хэсгийн зүйл бүр дээр ажиглагдаж байсан.
- Хүлээн авсан хандив, тусламжийн талаар Засгийн газрын зүгээс зөвхөн 6 компани дурдаж, эдгээр компаниудын гурван компани нь ямар нэгэн тоо дурдаагүй байсан болно. Дээр дурдсан дотроос Засгийн газар болон компанийн гаргасан маягт дээрээс зөвхөн Цайрт Минералын үзүүлсэн хандив тусламжийн мөнгөн дүн хоорондоо таарсан юм.
- Бусад бүх тохиолдолд Засгийн газрын маягт нь хандив, тусламжийн талаар мэдээлэл агуулаагүй, эсвэл маш бага хэмжээний тоо тавьсан, Засгийн газрын зүгээс тайлагнасан тоо нь компаниудын тайлагнасан тооноос ихээхэн бага байлаа.

Компаниудын маягт нь мөнгөн болон материаллаг туслалцааг аль алиныг нь агуулж байсан ба үүний тоонд автомашин, тоног төхөөрөмж, мал, засвар үйлчилгээ гэх мэт хэлбэрээр яам, агентлагууд, аймаг болон сумдад өгсөн туслалцааг хамарч байв. Маягтад тавигдах шаардлагын дагуу компанийн зүгээс орон нутгийн байгууллагуудад өгсөн мөнгөн тусламжийн мөнгөн дүн болон орон нутгийн харилцаа, тогтвортой хөгжилд зарцуулсан хөрөнгийн хэмжээг тайлагнахыг шаарддаг юм. Засгийн газрын зүгээс энэхүү маягтыг бүрэн хэмжээгээр тайлагнахын тулд эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон малчид зэрэг хандив тусламжыг ихээр авсан хүлээн авагч талын тухай бүрэн мэдээлэл цуглуулах шаардлагатай болно. Цаашид ч гэсэн Засгийн газрын зүгээс хандив, тусламжыг бүртгэх төвлөрсөн систем байхгүй тохиолдолд өөрийн харьяа газрууд нь ийм төрлийн хандив тусламжийг авсан эсэхийг бүртгэх боломжгүй юм.

Хүлээн авсан мөнгөн дэмжлэг, хандивыг нэгтгэн бүртгэх ямар нэгэн төвлөрсөн нэгдсэн системгүйгээр Засгийн газрын хувьд энэхүү хэсгийн дүнг цаашид цуглуулан тайлагнахад ихээхэн хэцүү байх болно.

Зарим компанийн маягт дээр мөнгөн тусламж хэмээн тэмдэглэгдсэн байсан зүйлс нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэрийг хамтатган багтаасан байлаа.

Маягтуудыг бэлтгэх нь

Компаниуд

Нилээд тооны компаниуд, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалт бүхий компаниуд нь үнэн зөв, бүрэн хэмжээний маягтуудыг бөглөн ирүүлсэн бөгөөд тэд шаардлагатай тохиолдолд ямар ч төрлийн тодруулгуудыг гарган өгөхөд бэлэн байлаа. Харин зарим компани нь маягтуудыг зөв, бүрэн бөглөх талаар анхаарал хандуулахгүй байж, бүрэн бус буруу мэдээлэл өгөн, нэмэлт тодруулга шаардсан үед өөрсдийн өмнө нь тайлагнасан бүх мэдээллээ огт өөр тоогоор шинэчлэн ирүүлж байлаа. Цөөн тооны компани нь зарим хэсэг дээр мэдээлэл өгөх боломжгүй, маш их ажилтай байгаа хэмээх тайлбарыг хүргүүлж байсан болно.

Засгийн газар

Засгийн газрын хүлээн авсан бүх төлбөр, хураамж болон мөнгөн дэмжлэгийг нэгтгэн дүгнэж гаргах ажлыг УТЕГ-ын Мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтэс хийж гүйцэтгэсэн. Хэдийгээр тухайн хэлтэсээс бидэнд тайлагнасан тоонууд нь буруу байсан хэмээх ямар нэгэн эргэлзээ байхгүй байгаа хэдий ч Засгийн газрын зүгээс өөрийн бүх салбар, байгууллагуудаас бүх шаардлагатай мэдээллийг цуглуулан авч боловсруулах үр дүнтэй систем одоогоор байхгүй байгаа нь ажиглагдсан болно.

Олон тооны төрийн байгууллага нь өөрсдийн хүлээн авсан мөнгөн дүнгийн хэмжээг тайлагнаагүй, болон тайлагнасан ч бүрэн, үнэн зөв тайлагнаагүй байлаа.

Маягтын загвар

Засгийн газрын зүгээс өөрийн маягт дээр тайлагнах шаардлагатай мэдээлэл болон компаниудын зүгээс мөн өөрийн зориулалтын маягт дээр тайлагнах ёстой мэдээллийн хооронд ихээхэн зөрүүтэй гарч байлаа. Үүний улмаас төрлүүд (тоон үзүүлэлтүүд) нь хоорондоо холилдох зэрэг үзэгдлүүд гарч нэгтгэн дүгнэн аудит хийх үйл ажиллагаанд хүндрэл учирч байлаа.

Маягтыг бөглөх зааварчилгаа

Талуудын бүрэн хэмжээгээр бөглөн тайлагнах ёстой маягт бүр дээр тухайн хэсэг болгон дээр шаардагдах мэдээллийг хэрхэн тайлагнах талаарх зааварчилгааг хангасан байлаа. Энэхүү зааварчилгаа нь зарим талаар ихээхэн ерөнхий гэж хэлж болох хэмжээнд байгаа бөгөөд үүний улмаас тухайн нэгэн хэсэг дээр ямар мэдээлэл шаардлагатай байгаа талаар оролцогч тал тус бүр өөрийн өөрийн хэмжээнд хөрвүүлэн ойлгох явдалд хүргэжээ. Хамгийн чухал нь тухайн зааварчилгаанууд нь татвар, хураамж нэг бүрийн онцлог талыг тусгаагүй тул үүний улмаас зарим зүйлсийг орхигдуулах болон буруугаар тайлагнах байдалд хүргэсэн байна. Үүний зарим жишээг дурдвал:

- Зарим компанийн жишээн дээр аваад үзвэл гаалийн татвар болон НӨАТ-ыг нэгтгэн тайлагнасан бол, Засгийн газрын зүгээс гаргасан тайланд зөвхөн гаалийн татварт төлсөн дүнг оруулж гаальд төлсөн НӨАТ-ыг орхигдуулсан байлаа.
- Зарим компани нь өөрийн бараа үйлчилгээг нийлүүлэгчид төлсөн НӨАТ-ыг өөрийн зүгээс Засгийн газарт төлсөн НӨАТ болгон бүртгэсэн тохиолдол байлаа.
- УТЕГ-ын мэдээлсэнээр тухайн компани нь өмнөх жилийн татварын өртэй байгаа тохиолдолд татварын алба зарим төлбөрийг өмнөх жилийн татварт суутган авдаг бөгөөд харин тухайн компанийн зүгээс дараагийн жилдээ л төлсөн төлбөрийг тухайн жилийн нийт хэмжээ хэмээн авч үзсэн байгаа бөгөөд үүний улмаас татварын алба зөвхөн 2006 оны татварт хамаарах дүнг нь тайлагнасан байх тохиолдол байх магадлалтай байна.

Бүлэг 5:

Асуудлууд

Цаг хугацаа болон цаг баримтлах нь

Энэхүү төслийн хэрэгжүүлэхэд учирсан саад тотгор нь тухайн төслийг эхлүүлэх хугацаа нь 2008 оны 12 сарын 17- ны өдрийг хүртэл хойшилсоноос үүдэлтэй. Үүний улмаас төслийн хэрэгжилтийн үеэр 12 сарын 31 болон 1 сарын 1 өдрүүд буюу хууль ёсний амралтын өдрүүд давхцан энэ үеэр компаниуд болон төрийн байгууллагууд ажиллаагүй юм. Хамгийн чухал нь гадаадын хөрөнгө оруулалттай, гадаад удирдлага бүхий компаниудын ахлах тушаалын ажилтнууд нь 3ул сарын баяр болон Шинэ жилийг өөрсдийн нутагт өнгөрүүлэхээр явсан байсан бөгөөд тэд ойролцоогоор 2 долоо хоногын дараа л Монголд ирэх байсан нь зарим компанид тавьсан бидний хүсэлтэд хариу өгөх хугацааг ихээхэн хойш татсан юм.

Үүн дээр нэмээд Монголд санхүүгийн жил 12 сарын 31-нээр дуусгавар болдогтой холбоотойгоор бидний зүгээс тодруулга хүсэмжилж, зарим зүйл дээр тайлбар хийх тэр үеэр татварын албаны ажилтнууд маш завгүй ажиллацгааж байлаа.

Эдгээр хүчин зүйлүүдийн улмаас энэхү төслийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө гарсан билээ.

Үүний хажуугаар төслийн үйл ажиллагааг гүйцэтгэхээр (30 өдөр) тохируулсан цаг хугацаа нь ихээхэн хэмжээний зөрүү илэрсэн зарим компанийн болон Засгийн газрын зүгээс асууж тодруулах үйл ажиллагааг явуулахад үл хүрэлцэхүйц хэмжээний шахуу хугацаа байсан нь ихээхэн дарамт шахалтыг мөн учруулсан билээ.

Бидний тодруулга хүссэн захидлын хариултууд нь 2008 оны 1 сарын 12-ны өдрийн тухайн долоо хоногийн сүүлийн хагаст л ирсэн бөгөөд урьд өмнө нь гэсэн өөрийн хариултыг явуулсан байсан зарим компаниуд дахин нягтлан засварласан тоогоо энэ үеэр мөн бидэнд илгээсэн болно.

Хамгийн чухал нь УТЕГ-ын тодруулга, хариулт нь 2008 оны 1 сарын 10-ны өдөр ирсэн явдал юм. Энхүү хариу нь зөвхөн бидний тодруулга хүссэн их хэмжээний зөрүүнүүд яагаад гарсан болох талаарх тайлбар болон түүнийг шалган, шинэчилсэн мэдээлэл зэргийг багтаахаас гадна Засгийн газраас анх тайлагнасан маягт дээр дурдсан эх мэдээллийн маш олон тоо, баримтыг дахин шалган нягталсан хариултуудыг агуулж байсан болно. УТЕГ-ын хувьд цохон дурдахад компаниудын зүгээс зөвхөн бидний гаргасан хүсэлтэд буй тухайн компанийн өөрийнх нь талаарх мэдээллийг л хангах ёстой бол УТЕГ нь зөвхөн 25 компанийг хамраад зогсохгүй Засгийн газрын харьяа бүх салбаруудын мэдээллийг мөн нягтлан шалгах үүрэгтэй байсан болохыг цохон тэмдэглэхийг хүсч байна.

Хэдийгээр дээр дурдагдсан хариунууд нь тогтоосон хугацаанаасаа хоцорч ирсэн ч гэсэн бид цаг зав гарган тэдгээр дээр үндэслэн өөрчлөлт хийсэн ба учир нь УТЕГ-ын хангасан мэдээлэл нь бидний үйл ажиллагаанд их хэмжээний нэмэлт дарамт учруулах ч мэдээлэл нь заавал нэгтгэгдэн орох хэмжээний чухал мэдээлэл байсан билээ.

Засгийн газрын зүгээс өгч буй мэдээлэл бүрэн бус байх

Аудитын үйл ажиллагааны үед гарсан ихэнх зөрөө нь Засгийн газрын зүгээс тайлагнасан маягт нь уул уурхайн компаниудын зүгээс төлсөн татвар хураамжийг компаниудын зүгээс дурдсаны адил бүрэн хэмжээгээр нарийвчлан гаргаагүй байснаас

үүдэлтэй байлаа. Энэхүү асуудлууд нь Засгийн газрын зүгээс хүлээн авсан төлбөрийн тайлангын маягт нь төлбөр хүлээн авсан бүх хүлээн авагч талын мэдээллийг хамруулаагүй байсан болон/ эсвэл уул уурхайн компаниудын зүгээс татвар төлбөрийг хураан авч буй хүлээн авагч төрийн байгууллага нь компани тус бүрээс авсан төлбөрөө бүрэн хэмжээгээр нарийн тусгаж, өргөн мэдүүлж чадаагүй байна.

Засгийн газрын харьяа олон тооны агентлагуудаас, орон нутгийн байгууллагуудаас гаргасан мэдээллүүдийг нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг ҮТЕГ-ын Мэдээлэл боловсруулалт, автоматжуулалтын хэлтэс гүйцэтгэсэн. Энэхүү хэлтсийг томилсон нь нэгтгэлийн үйл ажиллагааг зөвхөн тоонуудыг болвсруулах л явдал хэмээн үзэж байсантай холбоотой байж болох юм.

Гэхдээ уул уурхайн компаниудын төлж байгаа төлбөрийг хүлээн авч байгаа байгууллагуудын талаарх мэдээллийг цуглуулах тал дээр үр дүнтэй систем ажиллаж чадахгүй байгаа нь илэрхий байна. Цаашид Засгийн газрын зүгээс орон нутгийн ямар байгууллага уул уурхайн компаниудаас төлбөр хүлээн авч байгааг тогтоох үр дүнтэй ийм төрлийн системгүйгээр Засгийн газрын зүгээс бөглөх маягтад бүрэн хэмжээний нарийвчилсан үнэн зөв мэдээлэл тусгах боломжгүй юм.

Маягтуудын загвар

ОУИТБС-ын маягтуудын загвар нь заавал шаардагдахгүй төлбөрийн төрлүүдийг багтаасан эсвэл тайлагнах боломжгүй зүйлсийг агуусан, мөн зарим тодорхой гаргах ёстой зүйлсийг нэгтгэсэн хольсон байдлаар боловсруулагдсан байна. Үүнээс үүдэн компанийн болон Засгийн газрын тоо баримтуудыг харьцуулах үйл ажиллагаанд хүндрэл учруулж байлаа.

Маягтуудын үнэн зөв байдал

Ихэнх компанийн тоо мэдээлэл дээр гарсан их хэмжээний зөрүүний талаар тодруулга хийж өгнө үү хэмээн бидний тавьсан хүсэлтэд ихэнх компани нь холбогдох нарийвчилсан мэдээллийг гарган өгч тэдгээрийг баталгаажуулсан юм. Гэхдээ зарим компани нь бидний хүсэмжилсэн мэдээллээс гадна өөр бусад шинэ мэдээллийг гарган өгч, тэр ч байтугай урьд өмнө нь их хэмжээний зөрүү ажиглагдаагүй хэсгүүд дээр хүртэл шинэ шинэ тоо баримтуудыг ирүүлж байлаа. Энэхүү гэнэтийн өөрчлөлтийн цар хүрээ нь бидний өмнө нь бага хэмжээний хэмээн тодорхойлоод байсан зөрүүг их хэмжээний болгон өсгөх, зарим тохиолдолд өмнө нь Засгийн газрын тоо баримттай нийцсэн мэдээллийг шинээр өөрчлөн Засгийн газраас гаргасан тооноос огт өөр тоог бий болгох зэрэг асуудлуудыг үүсгэж байлаа.

Үүн дээр нэмээд хэлэхэд бидний зүгээс илрүүлэн гаргаж их хэмжээний зөрүү байгаа талаар мэдээлэл тодруулгыг хүссэн хүсэлтэд ҮТЕГ-аас 2008 оны 1 сарын 10-нд Майкрософт Ексел програмын ажлын хуудсан дээр гарган өгсөн билээ. Энэхүү хуудас нь анхлан өргөн мэдүүлсэн Засгийн газрын маягт дээр байсан бараг бүх тоог (зөвхөн ихээхэн хэмжээний зөрүү ажиглагдсаны улмаас бидний зүгээс татварын албыг шалган үзэхийг хүсэмжилсэн мэдээллээр тогтохгүй) багтаасан байсан бөгөөд үүнд мөн өөрчлөлтүүдийг оруулсан байсан нь зарим нь их хэмжээний өөрчлөлтүүд байсан. Үүнээс үүдэн урьд өмнө нь бага хэмжээний гэж үзсэн зарим тоонуудыг их хэмжээний болгон өөрчлөхөд хүргэж байсан.

Маягтыг бөглөх талаарх зааварчилгаа

Маягтууд дээр тухайн хэсгүүдийг хэрхэн бөглөх талаарх зааварчилгааг хавсарган оруулсан байгаа. Гэхдээ энэхүү зааварчилгаанууд ихээхэн ерөнхийлсөн байдалтай бөгөөд зарим зүйл дээр шаардагдах онцлог, ээдрээтэй зүйлсүүдийг бүрэн тусгаж

өгөөгүй байна. Үүний улмаас маягтууд дээр агуулагдсан тоо баримтуудын тоон дээр нийцэхгүй байх байдал гарч байлаа. Үүний жишээнд:

- Импортоор оруулж байгаа бараанд гаалийн албанаас ноогдуулдаг НӨАТ-ыг зарим хэсэг дээр гаалийн татвар хэмээн үзсэн, зарим маягт дээр НӨАТ-аас бусдаас нь орхигдуулсан байна.
- 2006 оны туршид төлсөн болон компанийн маягтад багтсан татвар нь тухайн жилийн өмнөх жилд тооцогдон Засгийн газрын маягт дээр 2006 онд ноогдуулсан татвар хэмээн бүртгэгдээгүй байна.

Маягтад багтах төлбөрүүдийн талаарх нэгдсэн үзэл баримтлал

Зарим тохиолдолд компаниуд Засгийн газар болон олон нийтийн байгууллагад төлсөн төлбөр дээр чухам ямар мэдээлэл шаардлагатай болохыг ойлгохгүй явдал ажиглагдаж байлаа. Үүний жишээнд өөрийн толгой компанид төлсөн ногдол ашгийг төрийн өмчийн ногдол ашиг хэмээн тайлагнасан тохиолдлыг дурдаж болно. Өөр нэгэн компани дотоодын худалдан авалтад төлсөн нийт НӨАТ-ыг Буцаан авсанаа хассан НӨАТ хэсэгт тайлагнасан байлаа. (Цаашид үзнэ үү)

НӨАТ

А. Уул уурхайн компаниуд ашигт малтмал экспортод гаргадаг тул үүнээс чөлөөлөгдөж, улмаар их хэмжээний буцаан авалттай байдаг байна. Ингэснээр уул уурхайн компаниуд нь ихээхэн хэмжээний авлагатай (татварын албанаас компанид төлөх) болдог ажээ. Компаниуд нь мөн дотоодын бараа үйлчилгээ худалдан авахад нийлүүлэгчид НӨАТ төлдөг бөгөөд энэ нь мөн буцаан авалттай байдаг.

НӨАТ-ыг маягтууд дээр хэрхэн тусгах талаар ихээхэн ээдрээтэй зүйлс ажиглагдаж байна. Маягтын “Буцаан авсанаа хассан НӨАТ” хэсэг дээр нэг компани 2006 онд үүссэн нэмэлтүүдийг өөрийн өмнөх буцаан авалт дээрээ нэмж тайлагнасан бол өөр нэг компани дотоодын бараа үйлчилгээнд төлж, улмаар буцаан авсан байсан НӨАТ-аа тайлагнасан байлаа.

Б. Компанийн төлөх ёстой өөр бусад татваруудтай (жишээ нь аж ахуйн нэгжийн орлогийн албан татвар) холбоотой өөр нэгэн хүндрэл нь хуримтлагдсан НӨАТ-аа тухайн татварт суутган тооцох явдал байв. Компани ч Засгийн газар ч гэсэн энэхүү төрлийн суутгалыг төлбөр хийсэн болон хүлээн авсан хэмээн үзэх эсэх тал дээр ямар нэгэн тодорхой ойлголт байхгүй байна.

Гаалийн татвар

Их хэмжээний хэмээн үзсэн маш олон тооны зөрүүнүүд компанийн болон Засгийн газрын маягтууд дээр илэрч байлаа.

А. Компанийн зүгээс тайлагнасан гаалийн татвар нь өөр өөр үндэслэлээр тооцогдож байна. Зарим компани нь өөрийн импортолсон бараанд төлсөн гаалийн татвар болон НӨАТ-ыг тайлагнасан бол зарим нь гаалийн бүрдүүлэлтийн хураамж, агуулахын төлбөр зэргийг өөрийн тооцоонд оруулжээ. Мөн бусад компаниуд онцгой татварыг гаалийн татварт хамруулах явдал их байлаа.

Б. Харин ГЕГ нь агуулахын төлбөр, бүрдүүлэлтийн зардлыг татвар хэмээн үздэггүй тул энэхүү тоог Засгийн газарт тайлагнах тоо хэмжээнээсээ хасаж тооцдог байна.

В. Бидэнд мэдээлсэнчлэн Засгийн газрын маягт дээр гаалийн татвар нэрээр туссан мөнгөн дүн нь ГЕГ-аас ҮТЕГ-т улирал тутамд гарган өгдөг мэдээлэл дээр үндэслэгдсэн

байдаг ч ГЕГ-аас бидэнд зориулан гарган өгсөн нийт 25 компанийн төлбөрийн баримтыг зөвхөн хоёроос бусад нь өмнө нь бидэнд УТЕГ-ын гарган өгсөн мэдээлэлтэй огт нийцэхгүй байлаа.

Цаг хугацааны ялгаа– “хасалт”

Хамгийн том хэмжээний зөрүү эсвэл мөнгөн дүнгийн хасалт нь одоогоор тухайн компани төлбөр хийсэн болон Засгийн газар төлбөрийг хүлээн авсан цаг хугацаанаас үүдэн гарсан байна. Эрдэнэт компани нь 59,152,701 мянган төгрөгийн ногдол ашгийг 2006 оны 12 сарын 29-нд шилжүүлсэн нь банкны гүйлгээний улмаас Засгийн газрын дансанд 2007 оны 1 сарын 2-ныг хүртэл ороогүй байжээ. Компанийн зүгээс энэхүү ногдол ашгийг 2006 оны тайландаа тусгасан бол 2007 оны санхүүгийн жил эхэлсэн хойно хүлээн авсан тул Засгийн газар нь үүнийг тайлангаас хасаж тооцсон байна. Энэ нь бидний илрүүлсэн цорын ганц хасаж тооцсон асуудал байсан ч үүний ижил асуудлууд бусад зүйлс дээр хүндрэл үүсгэж болох магадлалтай юм.

Төрийн байгууллагуудад үзүүлсэн мөнгөн тусламж

Нийт татвар, төлбөрт төлсөн мөнгөн дүнтэй харьцуулбал, хандив тусламжаар өгсөн мөнгө нь харьцангуй бага хэмжээтэй ч хандив, тусламжийн нөхцөл байдал нь ихэнх хэсэг дээр авлигатай холбоотой сэжигтэйгээр өндөр эрсдлийг үүсгэж байв.

А. Дээр энэхүү тайланд дурдсанчлан Засгийн газрын харьяа бүх яам, агентлагууд, аймаг, сум, орон нутгийн байгууллагууд болон бусад тусламж хүлээн авагчид нь тус тусдаа маягт бөглөөгүй, бөглөсөн ч гэсэн хүлээн авсан тусламжаа үнэн зөв, бүрэн бөглөөгүй байна. Энэ нь ихээхэн хэмжээний хандив тусламж өгсөн хэмээн тайлагнасан компаниудын тухайн тусламжыг хүлээн авсан тухай Засгийн газрын тайлан дээр огт дурдагдаагүй байгаагаас илт харагдаж байна. Үүний жишээнд 937,557 мянган төгрөгийн туслалцаа үзүүлсэн хэмээн тайлагнасан Бороо Голдын энэхүү дүн нь Засгийн газрын гаргасан тайланд огт тэмдэглэгдээгүй байгааг оруулж болно. Тухайн компанийн зүгээс энэ талаар тодруулга хүссэн бидний захидлын хариу болгон тус компани нь тухайн тусламжийг үзүүлсэн өдөр, нийт хэмжээ, төлбөр хүлээн авагчын нэр зэргийг нарийвчлан гаргаж ирсэн бол УТЕГ-ын зүгээс үүнийг нотлох ямар нэгэн баримт байхгүй тул энэ талаар ямар нэгэн мэдээлэл өгч чадаагүй юм. Татварын ажилтнуудын хэлсэнээр хандив, тусламжийг ялангуяа аймгийн хүрээнд үзүүлсэн мөнгөн тусламжыг бүртгэх нь маш хэцүү тул үүнийг баталгаажуулах боломжгүй болохоо мэдэгдсэн.

Б. Өөр нэгэн асуудал нь бараа болон үйлчилгээ хэлбэрээр үзүүлсэн хандив, тусламжид хамаарч байна. Компаниудын зүгээс энэхүү төрлийн тусламжаа гарсан зардал дээр нь үндэслэн мөнгөн дүнд шилжүүлэх (эсвэл зарим тохиолдолд тэд өөрсдийн бүртгэл дээр байгаа тухайн зүйлийн үнэлгээн дээр тулгуурлан) боломжтой байлаа. Хүлээн авагч байгууллагууд нь ийм төрлийн тусламжийн үнэн дүнг гаргах боломжгүй, эсвэл тухайн компанийн зүгээс мэдэгдэхгүй бол үндсэн үнэлгээнээс өөр үнийн дүн гаргаж болох байлаа.

В. Мөнгөн хэлбэрээр өгсөн хандив, тусламжийг бүртгэж байгаа ямар ч аймаг, сум, орон нутгийн байгууллага, тоног төхөрөмж зэргийн бүртгэлийг хөтлөхгүй байж болох бөгөөд хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байж болох юм. Тийм нөхцөлд тухайн байгууллагууд нь хүлээн авсан хандив, тусламжийн талаар нарийвчилсан мэдээллийг цуглуулахад хүндрэлтэй байж болох юм.

Г. Эмнэлэг, сургууль, цэцэрлэг, малчид зэрэг хандив тусламж хүлээн авагчдын талаарх мэдээлэл цуглуулах боломж нь ихээхэн асуудалтай байна.

Бүлэг 6:

Санал зөвлөмж

Энэхүү төслийн хэрэгжүүлэх хугацаанд бидний зүгээс санаа зовоож буй хэд хэдэн зүйлсийг ажигласан билээ.

Гэхдээ бидний үйл ажиллагаа нь одоо хэрэглэж байгаа системийн бүх сул талуудыг илрүүлэн гаргаж чадах найдвартай эх үүсвэр болохгүй юм. Энэхүү тайланд бид гол хэмээх асуудлуудыг тогтоон гаргаж, тэдгээрт хамаарах аргачлал, практик зөвлөгөөг гарган өгөхөөр хичээсэн болно. Их хэмжээний зөрүү бүхий тоо баримтууд, дүн зэргийг тогтоосон, үүний заримыг нь бүрэн хэмжээгээр тодруулан гаргаагүй зэрэг нь хэрэглэж байгаа үйл явцад оршиж буй хурц асуудлуудыг гэрчлэн гаргаж энэхүү үйл явцыг Засгийн газар болон компаниуд хэрхэн ойлгож байгааг харуулсан юм.

Энэхүү тайлангаар бид цаашид сайжруулах талаар санал зөвлөмж гарган, одоогоор Монголын ОУИТБС-ын хэрэглэж буй зарим үйл явцыг илүү үр дүнтэй болгох зөвлөмжүүдийг өглөө. Гэхдээ энэхүү зөвлөгөөнүүдийг практик амьдрал дээр нэвтрүүлэх нь шууд хийх ажил биш юм. Эдгээр санал, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт болон өргөн мэдлэг шаардагдах билээ.

Шийдэгдээгүй зөрүүнүүд

Зөрүүнүүд нь үндсэндээ дараах шалтгаануудын улмаас үүдэн гарч байна. Үүнд:

А. Засгийн газрын маягтууд нь уул уурхайн компаниудаас хүлээн авсан бүх төлбөрийг багтаагаагүй.

болон

Б. Хэрхэн бөглөх талаарх зааварчилгаа дутмаг байснаас Засгийн газрын болоод компанийн тайлангууд дээр буруу мэдээллүүд илэрч байсан.

Энэхүү гарч байгаа зөрүү болгоныг шалган тогтоох нь Засгийн газрын зүгээс өөрийн хийсэн өмнөх бүх үйл ажиллагааг дахин давтахыг шаардах бөгөөд харин энэ удаа төлбөр хүлээн авсан талаарх мэдээллийг бүх төрийн байгууллагуудаас гаргуулан авч нэгтгэх нэмэлт ажлыг гүйцэтгэх шаардлагатай болно.

Мөн ОУИТБС-аас зөрүү болон буруу мэдээлэл ихээр илэрсэн хэсгүүд дээр тэдгээрийг хэрхэн бөглөх талаарх нарийвчилсан зааварчилгааг гарган, үүний үндсэн дээр төрийн байгууллагууд өөрсдийн 2006 оны мэдээллийг дахин боловсруулахыг хүсэмжлэх үйл ажиллагааг мөн гүйцэтгэх шаардлагатай.

Ингэснээр нэгтгэлийг боловсруулан гаргахад маш их хэмжээний үйл ажиллагааг шаардах ба маш удаан хуучирсан мэдээллийг ашиглан, 2007 оны жилийн эцэс дууссан төрийн байгууллагууд маш их ачаалалтай ажиллаж байгаа зэргээс хамааран ОУИТБС-нь өнгөрсөн хугацааны мэдээлэл бус, харин цааш цаашдын нэгтгэлийн үйл ажиллагааг төлөвлөн, бэлтгэж байх шаардлагатай байна.

Бидний бодлоор 2006 онд гарсан зөрүүнүүдийг шийдвэрлэн шалтгааныг тогтоох нь маш бага үр дүнтэй байх ба харин энэхүү тайлан дээр дурдагдсан санал, зөвлөмжүүдийг цаашид учирч болох хүндрэлийг бууруулж, хийгдэх үйл ажиллагааг сайжруулах үүднээс үр дүнтэйгээр хэрэгжүүлж эхлэх нь ихээхэн үр дүнтэй болно гэдэгт бид итгэж байна.

Цаг хугацаа болон цаг баримтлах

2006 оны үйл ажиллагаанд аудит хийх энэхүү төслийн төлөвлөлтийн шатанд цаашид гарч болох хүндрэл, саатлууд болох баяр ёслолын үетэй давхацсан төслийн эхлэх хугацаа, санхүүгийн жил төгсгөл болж байгаа зэрэг зүйлсийг урьдчилан харж чадсангүй. Цаашид төслийн үр дүнг сайжруулахын тулд ийм төрлийн шахуу бөгөөд амралт ихтэй цагийг сонгохоос зайлсхийх хэрэгтэй.

Үүсээд байгаа зөрүүний талаар тодруулга хүсэж, энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэх хангалттай хэмжээний цагийг гарган өгөх зорилгоор, мөн эдний зүгээс өгсөн хариулт, тодруулгуудыг хянан үзэх зорилгоор энэхүү төслийн хугацааг ерөнхийд нь хоёр тусдаа бүрэлдхүүн хэсэгт хуваах шаардлагатай байна. Эхний бүрэлдхүүн хэсгийн хүрээнд маягтуудын дагуу тайланг шалгаж, харьцуулах, үүнээс гарсан төлбөрийн зөрүү, болон анхны байдлаар гарсан төслийг Засгийн газар болон компаниуд руу илгээн хариулт, тодруулга хүсэх үйл ажиллагааг багтаана. Дараагийн үе шат болох нэгтгэн тайлагнах үйл ажиллагаа эхлэхээс өмнө Засгийн газар болон компаниудад 2-3 долоо хоногийн хугацааг гарган өгч тухайн тодруулгуудыг хийх боломжийг олгох хэрэгтэй.

Энэхүү хандлагийг ашигласнаар тухайн компаниуд дээр зөвлөхүүд биечлэн ажиллах тохиолдолд л багахан хэмжээгээр тээврийн зардлыг өсгөх юм. Өөр нэгэн сонголт нь зөвлөхүүд нь факс болон e-мэйл харилцаа холбооны хэрэгслийг ашиглан төслийн анхны үе шатыг өөрийн байрлал, албан байранд явуулан, Засгийн газар болон компаниудын зүгээс эцсийн тодруулга, хариулт ирэхээс нааш Монголд заавал ирэхгүйгээр үйл ажиллагаагаа явуулж болно. Энэхүү хандлагыг ашиглах нь зөвлөхүүдийн байр, хоолны зардлыг бага хэмжээгээр бууруулах болно.

Засгийн газрын зүгээс өгч буй мэдээлэл бүрэн бус байх

Уул уурхайн компаниудаас төлбөр хүлээн авч байгаа талаарх мэдээллээ илгээхийг бүх яам, агентлаг, аймаг болон сумдад (бүх төрийн байгууллагад) хүргүүлэн, тухайн байгууллагуудаас мэдээллийг хүлээн авдаг байх системтэй байх шаардлагатай байна.

Хэрэв орон нутгийн болон бусад байгууллагуудын хүлээн авсан хандив, тусламжийг тайлагнаж байх шаардлагатай бол Засгийн газраас ямар компани нь хандив, тусламж үзүүлсэн болохыг тодорхой болгох, улмаар хандив, тусламж хүлээн авсан баримтыг цуглуулах үр дүнтэй энгийн системийг ажиллуулж эхлэх хэрэгтэй байна. Энэхүү хандлагийг хэрэгжүүлэх нэгэн боломж нь уул уурхайн компаниудын зүгээс тодорхой хугацааны давтамжтайгаар сум, аймаг болон төрийн байгууллагуудад олгосон мөнгөн тусламжийг тайлагнаж байх үүргийг үүсгэж болно

Мөнгөн бус хэлбэрээр олгосон хандив, тусламжийг бүртгэх нь ихээхэн сорилттой тулгарч байгаа билээ. Эдгээр нь мөнгөн бус тусламж тул байгууллагууд үүнийг бүртгэхгүй байх явдал байна. Хандив, тусламж үзүүлж буй уул уурхайн компаниуд нь өөрсдийн хандивласан бараа, үйлчилгээнд гарсан нийт зардлыг гаргасан бүртгэлтэй байж болох эсвэл үзүүлсэн тусламждаа хамаарах зардлуудыг гарган ирэх боломжтой. Эдгээр нь мөнгөн бус хэлбэрээр өгч байгаа тусламж ч гэсэн ингэснээр аймаг, сум, орон нутгийн байгууллагууд нь энэ тохиолдолд тухайн тусламжийг бүртгэн авах боломжтой болно. Орон нутгийн байгууллагууд ийм хэлбэрийн бүртгэл хөтөлдөггүй бол тэд тухайн тусламжийн мөнгөн үнэлгээг зөв үнэлж чадахгүй, мөнгөн үнэлгээгээр үнэлсэн ч гэсэн компанийн зүгээс тайлагнасан хэмжээтэй зөрчилдөх боломжтой. Дээр дурдсанчлан тайландаа энэхүү мөнгөн бус хэлбэрийн тусламж, дэмжлэгийн талаарх мэдээлийг багтаан тайлагнах нь тулгараад байгаа энэхүү асуудлыг даван гарахад тус болж болох юм. Өөр нэгэн сонголтот боломж нь уул уурхайн компаниуд тухай бүрдээ хандив

тусламжийн хуудсыг (жишээ нь тэг үнийн дүнтэй нэхэмжлэх, гэхдээ тухайн бараа үйлчилгээний зардлыг хавсаргасан байдлаар) хүлээн авагч талд өгч байж болох юм.

Маягтуудын загвар

Компаниудын хийсэн төлбөр олон Засгийн газрын хүлээн авсан талаарх мэдээллийг нэгтгэн дүгнэх зорилгоор маягтыг ижил загвараар гаргах хэрэгтэй байна. Бусад мэдээлэл цуглуулах бол үүнийг маягт дээр тусад нь зааж өгөх шаардлагатай.

Маягтуудын үнэн зөв байдал

Бидний гаргасан хүсэлтэд хариулт, тодруулга өгсөн байдлаас харахад зарим компаниуд маягтуудыг бөглөн тайлагнахад ихээхэн анхаарал тавьсан байсан бөгөөд харин зарим компанийн хийсэн гэнэтийн их өөрчлөлтийн байдлаас харахад тэд энэ үйл ажиллагаанд нухацтай анхаарал хандуулаагүй байна. ҮТЕГ-аас гаргасан тодруулга дээр хийгдсэн ихээхэн хэмжээний өөрчлөлтүүдээс харвал Засгийн газрын харьяа зарим байгууллагийн зүгээс энэ тал дээр дорвитой анхаарал хандуулаагүй болох нь харагдаж байсан.

ОУИТБС-ын зүгээс энэхүү санаачилгын ач холбогдлыг бүх талуудад ойлгуулах талаар анхаарал хандуулж, талуудад үнэн зөв, бүрэн хэмжээний мэдээлэл өгч байх талаар Засгийн газар болон уул уурхайн компаниудад сануулан, мэдүүлэх шаардлагатай байна.

Маягтын бөглөх талаарх зааварчилгаа

Маягт дээрх хэрхэн бөглөх талаарх зааварчилгааг хянан үзэж, шаардлагатай мэдээлэлд хамаарах онцлог зүйлсийг багтаах нь зөв. Зааварчилгааны хэсэг дээр илүү их нэмэлт зүйл шаардлагатай байгаа ихэнх татварын төрлийн (жишээ нь НӨАТ, Гаалийн татвар болон хасалт зэрэг) талаар энэхүү тайлан дээр өмнө дурдсан. Энэхүү тайлан нь маягтууд дээр багтаах ёстой бүх зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх зорилгогүй тул цаашид ч гэсэн бидний тодруулга хараахан авч чадаагүй зарим нэгэн тоо баримт дээр өөр өөр асуудлууд үүсэн гарч болохыг тэмдэглэх нь зүйтэй.

ОУИТБС-ын зүгээс маягтуудыг бэлтгэн гаргах үе шатанд нилээд тооны сургалтын үйл ажиллагааг явуулан, хэлэлцсэн болохыг дурдаж байсан. Бидний санал болгож байгаагаар энэхүү үйл явцыг дахин давтан хийж маягтыг хянан шалгаж, маягт болон зааварчилгааг засан сайжруулах ёстой болохыг дурдаж байна.

А. НӨАТ

НӨАТ нь ихээхэн ээдрээтэй татварын төрөл бөгөөд үүний улмаас төлбөр болон төлбөр хүлээн авсаныг нэгтгэхэд хүндрэлүүд учирч байсан. Гэхдээ хүндрэлүүд нь зөвхөн НӨАТ-ын хүрээнд байгаагүй, өөр бусад татваруудын хүрээнд мөн илэрч байсныг дурдах нь зүйтэй. (Жишээ нь аж ахуйн нэгжийн орлогийн албан татвар болон гаалийн татвар).

Нийт татварт хамаарах байдлаас гадна НӨАТ нь өөрөө ихээхэн ээдрээтэй зүйл тул үүнийг тайланг нэгтгэх үйл явцаас хасаж болох хувилбар байж болох юм. НӨАТ-ын аж ахуйн нэгжийн орлогийн албан татвар болон гаалийн татвар зэрэгтэй харилцан уялдаатай байдаг үндэслэлээр бидний зүгээс үүнийг маягтаас хасах нь олон тооны нэгтгэл, тодруулгатай холбоотой асуудлуудыг үүсгэх болно гэдэгт итгэж байна. Мөн суутган тооцдог татварууд дээр энэ байдлаас хамаарах асуудал ихээр үүсэх нь гарцаагүй.

Аль ч аргыг ОУИТБС-аас сонгон авсан НӨАТ-тай холбоотой ихээхэн хэмжээний нэмэлт зааварчилгаа, мэдээллийг маягтад багтаан НӨАТ болон бусад татваруудын харилцан уялдааг сайтар тайлбарлаж өгөх шаардлагатай. Тодруулан хэлбэл доорх төрлийн татварууд дээр хэрхэн тайлагнах талаарх тусгай хэсгийг нэмэн оруулж үүнийг Засгийн газрын болон компанийн маягт дээр багтаах шаардлагатай байна. Үүнд:

- Гааль дээр төлж байгаа НӨАТ (Зарим компаниуд үүнийн зөвхөн гаалийн татвар болгон мэдээлсэн байхад зарим нь огт оруулаагүй байсан.)
- НӨАТ-ыг бусад төрлийн татварт суутган тооцох
- Дотоодын бараа үйлчилгээ худалдан авахад төлсөн НӨАТ

Үүн дээр нэмээд хэлэхэд НӨАТ-ын хуримтлагдсан буцаан авалт, үүний хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг цаашид авах хэрэгтэй эсэхийг сайтар нягтлан шалгахыг хүсэмжилж байна.

Б. Гаалийн татвар

Маягт дээрх зааварчилгаанууд нь компаниуд болон Засгийн газраас яг ямар мэдээлэл авах шаардлагатай байгаа талаар тодорхой зааварчилгааг багтаах хэрэгтэй. Тодруулан хэлбэл импортоор оруулсан бараа бүтээгэдхүүнд гаалийн байгууллагийн ноогдуулан хураасан НӨАТ-ыг илүү тодорхой болгож өгөх хэрэгтэй байна.

ОУИТБС нь мөн гаалийн агуулахын үйлчилгээний хураамжыг тайланд багтаах шаардлагатай эсэх дээр өөрийн анхаарлыг хандуулахыг зөвлөж байна.

Дээр дурдагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд учирч болох нэгэн асуудал нь зарим компаниуд гааль дээр төлсөн нийт төлбөрийг татвар бүрээр нь ялган салгаж тайлагнах боломжгүй байх явдал юм. Гэхдээ бидний зүгээс энэ асуудал дэр санал гаргах боломжтой эсэх нь тодорхойгүй бөгөөд гаалийн албанаас хэрхэн татварыг хуваан ноогдуулдаг талаар тодорхой бус байна. Хэдийгээр гаалийн байгууллагаас бидэнд мэдээлэхдээ гаалиас олгож байгаа гэрчилгээн дээр тухайн татвар тус бүрээр нь мөнгөн дүнг гаргасан байдаг болохыг баталгаажуулсан. Энэхүү асуудал нь гаалийн байгууллагийн үйл ажиллагаанаас хамаараад үүсэж байгаа гэдгийг батлах зүйл бидэнд одоогоор үгүй байна. Гэхдээ зарим компаниуд гаалийн газраас өгсөн гэрчилгээг үл тоомсорлон өөрийн гаалийн мэдүүлгийг бүртгэл тооцоондоо ашиглах явдал байна. Энэ нь гаалийн хийсэн үнэлгээнээс зөрүүтэй байх нь аргагүй юм. Зарим компаниуд нь зүгээр л гаальд төлсөн нийт хэмжээг (гаалийн татвар, НӨАТ, хураамж) ялган зааглалгүйгээр өөрийн бүртгэлд хамруулдаг байна.

В. Цаг хугацааны ялгаа– “хасалт”

Энэхүү асуудал нь зөвхөн цөөхөн тохиолдолд гарч болох бөгөөд үүнээс гарах хүндрэлийг зөвхөн Засгийн газрын салбар агентлагуудын зүгээс санхүүгийн жил дууссаны дараах цөөхөн өдрүүдэд багтаан хасалтыг тооцон хийснээр даван туулж болно. Гэхдээ энэхүү асуудлыг маягтын зааварчилгаа дээр тусгах хэрэгтэй ч бидний одоогийн итгэж байгаагаар ямар нэгэн өөрчлөлт шаардлагагүй байна.

Г. Төрийн байгууллагад үзүүлсэн мөнгөн тусламж

Ил тод байдалд нөлөөлөх ихээхэн учир шалтгаантай тул хандив, тусламж нь ил тод байдлын чухал боловч ихээхэн эрсдэлтэй хэсэг юм. Энэхүү хэсгийн өмнөх зүйл дээр бидний санал болгосон Засгийн газрын зүгээс гарган өгсөн мэдээлэл нь бүрэн бус байсан талаарх нарийвчилсан мэдээлэл нь энэхүү хэсэг дээр гарч байгаа хүндрэлүүдийг цаашид даван туулахад ихээхэн чухал хэмээн үзэж байна.

Бүлэг: 7

Дүгнэлт

Энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэх үеэр Засгийн газар болон компаниудын зүгээс үйл явцын хувьд ч тоо хэмжээний хувьд ч их хэмжээний болон бусад төрлийн мөнгөн дүнгийн зөрүү болон санаа зовоох хэсгүүд ажиглагдаж байсан билээ. Зарим зөрүүг тодруулан шалгаж бодит байдлыг тогтоон энэхүү тайланд оруулсан ч гэсэн өөр бусад ихээхэн асуудлууд шийдэгдээгүй, тодроогүй үлдсэн билээ. Үүний улмаас бидний зүгээс эдгээр нь хэрхэн үүссэн, ямар шалтгааны улмаас үүдсэн болохыг нарийвчлан тогтоох боломжгүй байсан болно. Гэвч бидний итгэж байгаагаар зөрүүний цаана байгаа олон тооны асуудлуудыг тодруулан шийдвэрлэсэн бөгөөд энэ нь ч гэсэн бидний шийдэж чадаагүй зөрүүнүүдийн учрыг цаашид тайлахад туслалцаа үзүүлэх байх хэмээн найдаж байна.

Тиймээс бидний өгч буй санал зөвлөмжүүдийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нь энэхүү төслийн хүрээнд тулгарсан олон тооны хүндрэлийг цаашид шийдэхэд тус болох буйзаа.

Өөрсдийн гүйцэтгэсэн үйл ажиллагаан дээрээ үндэслэн энэхүү тайлан дээр нэгтгэн дүгнэсэнчлэн бид дараах санал бодлыг өөрсдийн зүгээс илэрхийлж байна. Үүнд:

А. Бидний хэрэгжүүлсэн үйл явц нь хангалттай хэмжээний, нарийвчилсан зааварчилгааны хувьд дутмаг байсан бөгөөд бидэнд гарган өгсөн мэдээлэл дээр хэд хэдэн нийцэхгүй, ойлгомжгүй зүйлс тааралдаж байлаа.

Б. Компаниудаас хүлээн авсан мэдээллийн чанар нь дээр дурдсан зарим хэсгүүд дээр нийцэхгүй зүйлс гарч байсан хэдий ч нийтэд тодорхой хэмжээнд сайн байсан болно.

В. Засгийн газрын зүгээс бидний хүлээн авсан мэдээлэл нь чанарын хувьд ихээхэн дутагдалтай байлаа. Тодруулан хэлбэл, Засгийн газрын зүгээс бөглөсөн маягтууд нь бүрэн бус, эдгээрийн талаар тодруулга хүссэн бидний хүсэлтэд өгсөн хариулт нь хүсэмжилсэн, хэрэгтэй мэдээллийг агуулаагүй байсан.

Г. Энэхүү үйл явц нь бүхэлдээ ихээхэн учир дутагдалтай байсан ба эдгээр нь энэхүү тайланд дурдагдсан хүчин зүйлсүүдээс ялангуяа дээр А болон В хэсгүүд дээр дурдсан шалтгаанаас ихээхэн хамаарсан болно.

Төгсгөлд нь бидний зүгээс бидний үйл ажиллагаанд гүн туслалцаа үзүүлсэн Монголын ОУИТБС-ын ажилтан ноён Шарын Цолмон болон хатагтай Түмэнжаргалын Хүрэлчимэг нарт талархал илэрхийлье. Тэд уул уурхай салбарын талаар болон Засгийн газрын харьяа агентлагуудын үйл ажиллагааны талаарх үнэт мэдээллээр хангаж, маш үнэт тусламжийг үзүүлсэн билээ. Баяр ёслол давхацсан энэ цаг үед маш бага хугацаанд багтаан уулзалтуудыг зохион байгуулах, компаниудаас мэдээлэл авах зэрэг ажилд гүн туслалцаа үзүүлсэн ноён Ш.Цолмонгийн туслалцаагүйгээр энэхүү ажлыг гэрээнд заасан хугацаанд нь гүйцэтгэх боломжгүй байх байсан билээ.

Крейн Вайт энд Ассоушиэтс
Захиалгат нягтлан бодогч нар, Австрали
2008 оны 1 дүгээр сарын 14

Товчлолууд

ОУИТБС	Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод байдлын Санаачилга (Олон улсын)
МОУИТБС	Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод байдлын санаачилга
ОУИТБС-ын Ажлын алба	Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын Ажлын Алба
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ҮТЕГ	Үндэсний Татварын Ерөнхий Газар
СЭЗЯ	Санхүү, Эдийн Засгийн Яам
MNT	Монгол Төгрөг
Төрийн байгууллагууд	Яам, агентлагууд болон аймаг, сум, орон нутгийн байгууллагуудыг ерөнхийлөн нэрлэсэн нэр

Хавсралтууд

А	Маягтуудын дагуух зөрүүний нэгтгэл
Б	Компаниуд болон Засгийн газрын маягтуудын зөрүүний нэгтгэл
В	Маягтуудад гарсан их хэмжээний зөрүүний нэгтгэл
Г	Маягтуудад хийсэн өөрчлөлт, тодруулгын нэгтгэл
Д	Гаалийн татварын нэгтгэл

Компанийн тайлангууд

Алтан Дорнод Монгол
Адуунчулуун
Багануур
Бороо Голд
Чинхуа МАК Нарийн Сухайт
Коулд Голд
Дацан Трейд
Эрдэс Холдинг
Эрдэнэт УБК
Гацуурт
Айвенхоу Майнз Монголиа Инк
Жамп
Монголын Алт
Эм Жи Эйч
Монгол Газар
Монголросцветмет
Петро Чайна Дайчинь Тамсаг
Шарын Гол
Шим Технологи
Шинь Шинь
Шивээ Овоо
Шижир Алт
Тавантолгой
Цайрт Минерал
Улз Гол

Компаниуд болон Засгийн газрын маягуудын зөрүүний нэгтгэл																							Хавсралт Б					
Аж ахуйн нэгжийн нэр	Шарын Гол	Багануур	Чинхуа МАК Нарийн сухайт	Айвенхоу Майнз Монголиа Инк	Цайрт Минерал	Бороо Голд	Шижир Алт	Улз Гол	Жамп	Коулд Голд	Шин Шин	Эрдэс Холдинг	Монголр осцветиет	МАК	Петро Чайна	Дацан Трейд	Алтан Дорнод Монгол	Гацуурт	Шивээ Овоо	Эрдэнэт	Адуунчулуун	Шини Технолож	Монгол Газар	Эм Жи Эйч	Тавантолгой	Нийт	Зөрүү	
Компани																												
Нийт татвар	893,349	2,371,327	115,368	1,206,043	1,221,902	4,803,208	3,868,855	386,429	616,861	176,010	59,915	49,378	1,385,200	471,889	58,402	243,606	2,372,440	523,325	798,218	309,305,310	217,938	249,032	0	0	2,189,362	333,583,355		
Нийт төлбөр	296,826	1,058,548	768,280	7,553,267	2,845,316	5,780,381	1,472,097	247,443	79,268	127,001	526,296	331,082	247,700	559,011	621,743	230,133	4,033,105	1,482,069	276,894	30,067,174	37,945	4,072	77,889	842,884	1,041,319	60,607,740		
Нийт хураамж	0	0	1,554,886	17,867	9,602	25,644	0	0	475	0	148,626	2,550	224,872	0	215,969	0	0	0	18	9,614	419	0	0	0	1,316	2,211,858		
Нийт ногдол ашиг	0	31,147	0	0	0	0	950,000	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	96,426,932	0	0	0	0	1,032,357	98,440,436		
Нийт төлбөр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	3,010,951	0	0	0	0	0	0	0	0	0	2,007	3,012,958		
Нийт хандив	31,589	0	171,618	656,358	120,653	937,557	6,000	750	0	6,500	9,434	4,655	25,308	32,308	51,840	0	196,790	37,800	1,220	1,868,000	7,320	71,163	0	0	0	4,236,863		
Нийт төлсөндүн	1,221,763	3,461,022	2,610,141	9,433,535	4,197,473	11,546,790	6,296,953	634,622	696,604	309,511	744,270	387,665	1,883,080	1,063,208	3,958,905	473,738	6,602,335	2,043,194	1,076,349	437,677,031	263,622	324,267	77,889	842,884	4,266,361	502,093,210		
Шалгах	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
Засгийн газар																												
Нийт татвар	285,305	2,461,033	65,163	1,288,491	2,939,602	91,957	3,322,734	256,305	327,953	185,349	14,369	19,799	728,563	599,506	43,773	10,235	1,313,576	533,858	761,882	306,189,324	216,404	305,197	28,898	9,095	2,335,296	324,333,669	-9,249,687	
Нийт төлбөр	302,806	1,067,001	777,859	270,455	2,770,812	5,116,622	1,336,265	242,160	290,116	101,253	1,000	297,727	174,036	167,999	0	246,985	2,566,028	1,521,058	277,342	22,846,655	37,406	0	231,466	590,807	1,055,045	42,288,902	-18,318,838	
Нийт хураамж	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
Нийт ногдол ашиг	0	29,988	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	37,275,291	0	0	0	0	1,032,357	38,337,637	-60,102,799	
Нийт төлбөр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2,671	0	0	0	0	0	0	0	0	0	0	2,671	-3,010,287	
Нийт хандив	20,000	0	31,617	0	120,653	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	15,000	86,909	29,290	303,469	-3,933,394	
Нийт авсандүн	608,111	3,558,023	874,639	1,558,946	5,831,067	5,208,579	4,658,998	498,465	618,069	286,602	15,370	317,526	902,599	767,504	46,444	257,220	3,879,604	2,054,916	1,039,224	366,311,270	253,810	305,197	275,364	686,811	4,451,988	405,266,347	-96,826,863	
Зөрүү	-613,652	97,001	-1,735,502	-7,874,589	1,633,594	-6,338,211	-1,637,954	-136,157	-78,534	-22,909	-728,900	-70,139	-980,481	-295,704	-3,912,461	-216,519	-2,722,730	11,722	-37,125	-71,365,760	-9,812	-19,069	197,476	-156,073	185,628	96,826,863		

Хавсрант В																																																
Мягтудад гарсан их хэмжээний зөрүүний нэгтгэл (Мөнгөн төгрөгөөр)																																																
Аж ахуйн нэгжийн нэр	Шарын Гол	Багануур	Чинхуа МАК Нарийн сүхэйг	Айвенхоу Майнз Монголиа Инк	Цайрт Минерал	Бороо Голд	Шижир Алт	Улз Гол	Жанп	Коулд Голд	Шин Шин	Эрдэс Холдинг	Монгол осцвети ет	МАК	Петро Чайна	Дацан Трейд	Алтан Дорнод Монгол	Гацуурт	Шнвээ Овоо	Эрдэнэт	Адуучу луун	Шин Технологи	Монгол Газар	Эн Жи Зич	Тавантол гой	НИИТ																						
Харилцагч татварын хэлтэс	Дархан-Уул аймаг	УТЕГ	Өмнөговь аймаг	УТЕГ	Сүхбаатар аймаг	УТЕГ	УТЕГ	Дорнод аймаг	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг	УТЕГ	Баянхонгор аймаг	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг	УТЕГ	Нийслэлийн татварын газар	Нийслэлийн татварын газар	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг	УТЕГ	Сэлэнгэ аймаг	Говь-Сүмбэр аймаг	УТЕГ	Дорнод аймаг	УТЕГ	Нийслэлийн татварын газар	Өмнөговь аймаг	Өмнөговь аймаг																							
2.a	Төлсөн татварууд																																															
2.a.1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар																																															
2.a.2	Бүцээн авснаа хэссэн Нэмэгдсэн өртөлийн албан татвар																																															
2.a.3	Галийн татвар																																															
2.a.4	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар																																															
2.a.5	Үн хөдлөх хөрөнгийн албан татвар																																															
2.a.6	Онцгой албан татвар (шахах тослох материал импортлосон бол)																																															
2.a.7	Автомобилийн, дизелийн тулшний албан татвар																																															
2.a.8	Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар																																															
2.б	Төлбөр																																															
2.б.1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр																																															
2.б.2	Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөв аверлийн төлбөр																																															
2.б.3	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордон нөхөн төлбөр																																															
2.б.4	Газрын төлбөр																																															
2.б.5	Ус ашигласны төлбөр																																															
2.б.6	Ойлоос мод, түлээ бэлтгэсний төлбөр																																															
2.б.7	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ахлын байрны төлбөр																																															
2.б.8	Түгээмэл тарагцтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр																																															
2.в	Хураамж, үйлчилгээний хөлс																																															
2.в.1	Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн ТЗБ-д төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж																																															
2.в.2	Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн ТЗБ-д төлсөн үйлчилгээний хөлс																																															
2.в.3	Галийн үйлчилгээний хураамж																																															
2.г	Төрийн болон орон нутгийн өгчийн ногдол ашиг																																															
2.г.1	Төрийн өмчийн ногдол ашиг																																															
2.г.2	Орон нутгийн өмчийн ногдол ашиг																																															
2.д	Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд																																															
2.д.1	Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий ААН-ийн ЗГ-т ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр																																															
2.д.2	Газрын тосны татвар																																															
2.е	Төрийн байгууллагад үзүүлсэн мөнгөн дэмжлэг																																															
2.е.1	Компаниас яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг																																															
2.е.2	Компаниас аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг																																															
2.е.3	Компаниас суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг																																															
2.е.4	Компаниас орон нутгийн байгууллагад үзүүлсэн мөнгөн дэмжлэг																																															
2.е.5	Компаниас орон нутгийн харилцаа, тогтвортой хөгжилд зориулсан үзүүлсэн хөрөнгө																																															
Нийт их хэмжээний зөрүү																							-566,762	0	-1,756,472	-7,732,386	1,657,581	-5,969,122	-1,280,000	-98,295	-53,463	0	-727,940	-45,593	-946,506	-226,687	-3,907,375	-202,187	-2,323,963	-11,691	-72,699	-70,805,643	0	-2,969	165,725	-188,519	0	95,094,967
Нийт бага хэмжээний зөрүү																							-46,891	97,001	20,970	-142,204	-23,986	-369,089	-367,964	-37,863	-25,071	-22,909	-960	-24,546	-33,976	-69,017	-5,086	-14,331	-398,768	23,413	36,574	-660,117	-9,813	-16,101	31,751	32,445	185,628	-1,731,896
Нийт зөрүү																							-613,652	97,001	-1,735,502	-7,874,589	1,633,595	-6,338,211	-1,637,954	-136,157	-78,534	-22,909	-728,900	-70,139	-980,481	-295,704	-3,912,461	-216,519	-2,722,730	11,722	-37,125	-71,365,760	9,813	-19,069	197,476	-156,073	185,628	-96,826,863

Гаалийн татварын нэгтгэл	Маягт дээрх зөрүүнүүд	Компанийн тодруулга	Засгийн газрын тодруулга	Хавсралт Д Тодруулан засварласан зөрүүнүүд
Багануур	74,923			74,923
Чинхуа МАК Нарийн Сухайт	-56,999	-39,500		-96,498
Айвенхоу Майнз Монголиа Ин	112,480			112,480
Цайрт Минерал	60,120			60,120
Бороо Голд	-9,260			-9,260
Шижир Алт	-216,062	-104,425		-320,487
Улз Гол	-23,580	1,155		-22,424
Жамп	119,643	-213,185		-93,543
Коулд Голд	4,651			4,651
Шин Шин	-45,590			-45,590
Монголросцветмет	-703,558			-703,558
МАК	-32,220			-32,220
Петро Чайна	-35,925			-35,925
Дацан Трейд	10,235			10,235
